

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТ**

2022.12.01

Булган аймаг

№	Үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО			
1.1. Эрүүл мэнд. Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэн төлөвшүүлж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.			
1.1.1	Эрүүл мэндийн байгууллагуудын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулж, оношилгоо, эмчилгээний дэвшилтэт технологийг нэвтрүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай, тэгш, хүртээмжтэй үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	2022 онд эрүүл мэндийн салбарын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулах зорилгоор 1418.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар барилга байгууламж, засвар үйлчилгээг хийж, үйлчлүүлэгчдэд тав тухтай, ээлтэй орчныг бүрдүүлээд байна. Үүнд: улсын төсвийн 800.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Орхон сумын Эрүүл мэндийн төвийн 10 ортой эмнэлгийн барилгын суурийг бүрэн тавьж, 300.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Нийгмийн эрүүл мэндийг дэмжих төвийн барилгын их засвар хийгдсэн. Мөн орон нутгийн төсвийн 218.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн дотрын тасгийн их засвар хийгдэж, 80.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн моргийн барилга баригдаж, 20.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Нийгмийн эрүүл мэндийг дэмжих төвийн цонхыг шинэчлэв. Эрүүл мэндийн салбарт эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх чиглэлээр 1952.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 48 нэр төрлийн нэн шаардлагатай, яаралтай түргэн тусламжийн болон эрт илрүүлгийн үзлэг шинжилгээний тоног төхөөрөмжөөр хангагдаж, 2022 оны жилийн эцсийн байдлаар эрүүл мэндийн салбарын эмнэлгийн тоног төхөөрөмжийн стандарт хангалт суурь түвшнээс 4.5 пункт, зорилтот түвшнээс 1.5 пунктээр тус тус нэмэгдэж, 89.5 хувьд хүрсэн байна. Төрөлтийн нийлбэр коэффициент дунджаар 1.3 болж, нялхсын эндэгдэл 10.9 промилл болж, суурь түвшнээс 3.6 промиллоор буурч, эхийн эндэгдэлгүй ажиллаж байна.	75.0
1.1.2	Эрүүл мэндийн байгууллагуудын яаралтай тусламжийн чадавхыг сайжруулж, техник, тоног төхөөрөмж, автомашинаар үе шаттай хангана.	2022 онд эрүүл мэндийн байгууллагуудын яаралтай тусламжийн техник, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх чиглэлээр улсын төсвийн 147.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Могод, Рашаант, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сумын Эрүүл мэндийн төв хяналтын монитор, хүчилтөрөгч өтгөрүүлэгч, амьсгал зүрх судас дэмжигч аппарат зэрэг 14 нэр төрлийн тоног төхөөрөмжөөр хангагдав. Алслагдсан багийн иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг хүргэх, багийн эмчийн оношилгоо, эмчилгээг сайжруулах зорилгоор улсын төсвийн 75.6 сая, орон нутгийн төсвийн 11.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 10 эрүүл мэндийн байгууллагыг "Мобайл тоног төхөөрөмж"-өөр хангаж, яаралтай тусламжийн чанар, зайн оношилгоо, эмчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн. Автомашины бэлэн байдлыг хангах чиглэлээр улсын төсвийн 89.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хангал, Хишиг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвд УАЗ-22069 маркийн автомашин, аймгийн Нэгдсэн эмнэлэгт 155.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Land Cruiser 78 загварын эмнэлгийн түргэн тусламжийн автомашиныг олгосноор эрүүл мэндийн салбарын автомашины парк шинэчлэл 90.0 хувьд хүрээд байна.	96.7

1.1.3	Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулж, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.	2022 онд хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгааг 23 зорилтот сэдвээр зохион байгуулан, уулзалт, ярилцлага хэлэлцүүлгийг 3 удаа, нийгмийн эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүд 23, нэрэмжит сарын аян 11 удаа, хөдөлгөөнт болон цахим 563 сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 74017 иргэнийг хамруулсан. Өмнөх онтой харьцуулахад эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалт сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоо 8.1 хувь, иргэдийн эрүүл мэндийн мэдлэгийн түвшин 5.8 хувиар өссөн байна. "Эрүүл мэнд" хөтөлбөрийн хүрээнд аймгийн "Засаг даргын нэрэмжит" нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг 8 суманд зохион байгуулж, 3899 иргэнийг хамруулснаас эмэгтэйчүүд, хоол боловсруулах, мэдрэл, дотоод шүүрлийн эрхтэн тогтолцооны эмгэг, өвчлөл 1965 тохиолдлыг илрүүлж, яаралтайгаар 8 иргэнийг хэвтүүлэн эмчилж, 263 иргэнийг төрөлжсөн нарийн мэргэжлийн шатлалын эмнэлэгт хүргүүлсэн. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/139 дүгээр тушаалын дагуу "Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд" хамрагдвал зохих 59553 иргэнээс 17994 буюу 30.3 хувийг хамруулав. Эрт илрүүлгийн үзлэгт хамрагдагсдын 48.1 хувь нь эрэгтэйчүүд, 51.9 хувь нь эмэгтэйчүүд байгаа бөгөөд ходоодны улайлт, шалбархай, элэг, цөс, нойр булчирхайн үрэвсэл, бамбайн зангилаат өөрчлөлт, зүрхний хэм алдалт, илчлэгээс шалтгаалсан таргалалт зэрэг өвчин, эмгэг зонхилон илэрч байна. Иргэдийн эрүүл мэндийн боловсрол дээшилснээр эрт илрүүлгийн үзлэгт хамрагдах идэвх нэмэгдэж байна. Аймгийн 0-17 насны хүүхдүүдийн 63.2 хувийг амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан нь өмнөх онтой харьцуулахад 48.2 пунктээр өссөн байна. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан хүүхдүүдээс 80.9 хувь нь шүдний өвчлөлтэй илэрч, 2072 хүүхдийг бүрэн эмчилсэн.	95.0
1.1.4	Халдварт өвчний тандалт сэргийлэлтийг сайжруулж, эрт илрүүлэх, идэвхтэй үзлэгийг зохион байгуулж, хариу арга хэмжээний бэлэн байдлыг дээшлүүлнэ.	Халдварт өвчний эрт илрүүлэг, идэвхтэй үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор сүрьеэ өвчний идэвхтэй илрүүлэг үзлэгт 1175 хүнийг хамруулж, 8 тохиолдол шинээр илэрч 100 хувь эмчилгээнд хамруулсан. Аймгийн хэмжээнд эмчлэгдэж байгаа сүрьеэгийн 21 тохиолдлын хавьтлын үзлэгийн хамрагдалт 89.1 хувь, эмчилгээний чанар 94.5 хувьд хүрч өмнөх оноос 9.2 пунктээр өссөн. Тэмбүү илрүүлэг үзлэгт 2264 хүнийг хамруулж, 17 шинэ тохиолдол, 9 хавьтлыг илрүүлэн бүрэн эмчлэв. 2022 онд аймгийн хэмжээнд томуугийн эсрэг вакцинжуулалтад 5020 хүүхдийг хамруулж, вакцинжуулалтад хамрагдсан хүүхдийн тоо суурь түвшнээс 5.6 дахин, зорилтот түвшнээс 2.6 дахин өссөн. Шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчний хариу арга хэмжээний бэлэн байдлын хангалтыг нэмэгдүүлэх зорилгоор улсын төсөв болон Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар 948.4 сая төгрөгийн санхүүжилтээр 13 нэр төрлийн хамгаалах хувцас хэрэгсэл, 10 автомакс, 4000 ширхэг аюулгүй хайрцаг, 5 нэр төрлийн вирусийн эсрэг эм бэлдмэл, 3024 ширхэг ПГУ оношлуур, 1500 ширхэг түргэвчилсэн оношлуурыг татан авч, аймгийн хэмжээнд хариу арга хэмжээний 3 сарын нөөцийг бүрдүүлж, бэлэн байдлын нөөцийн хангалт суурь түвшнээс 24.0 пункт, зорилтот түвшнээс 14.0 пунктээр нэмэгдэж, 84.0 хувьд хүрснээр халдварт өвчинтэй тэмцэх, хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд хангалттай нөхцөл бүрдсэн.	90.0
1.1.5	Төрөлжсөн, сувилахуйн тусламж үйлчилгээг өргөжүүлэн, чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор "Ахмадын өргөө"-г түшиглэн "Сувилахуйн төв"-ийг байгуулахаар төлөвлөн, тооцоо, судалгаа хийж байна. 2022 онд анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд сувилахуйн 11 төрлийн тусламж үйлчилгээг гэрээр 1351 иргэнд үзүүлсэн. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдрийг угтан "Хөгжлийн бэрхшээл ба тэгш хүртээмж" сарын аяны хүрээнд аймгийн сувилагч нарын холбооны сувилагч, тусгай мэргэжилтнүүд байнгын асаргаа шаардлагатай, хэвтэрт байдаг хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, хүүхдүүдэд 6 төрлийн сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлэв. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 16 сумын эрүүл мэндийн төвийг компьютер, тоног төхөөрөмжөөр ханган, сувилахуйн 11 анхан шатны бүртгэл маягыг цахимаар хөтөлж, эмийн эмчилгээний бүртгэлийг цахим хэлбэрт шилжүүлсэн нь сувилахуйн тусламж үйлчилгээний гардан үйлдэлд зарцуулах цаг нэмэгдэн, чанар хүртээмж сайжирсан.	50.0

1.1.6	Эрүүл мэндийн ажилтны чадавхыг сайжруулж, нийгмийн хамгааллыг дэмжинэ.	<p>Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадварыг сайжруулах зорилгоор төгсөлтийн дараах үндсэн мэргэшил олгох сургалтад 7 их эмч, төрөлжсөн мэргэшил олгох сургалтад 5 их эмч, 11 сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн, мэргэжил дээшлүүлэх сургалтад 5 их эмч, 6 сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн хамрагдав. Мөн ажлын байрны болон танхимын "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлага", "Коронавируст халдварын үеийн эрүүл мэндийн удирдлага, зохион байгуулалт", "Коронавируст халдварын эмнэл зүйн удирдамжийн хэрэгжилт", "Эмнэлгийн тусламж үйлчилгээ дэх хүний эрхийн асуудал" зэрэг сэдэвт 45 удаагийн сургалтад давхардсан тоогоор 706 эрүүл мэндийн ажилтан хамрагдсан. Аймгийн хэмжээнд 183 сувилагч, 128 эмнэлгийн тусгай мэргэжилтэн ажиллаж байгаа бөгөөд сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний хангалт 85.0-90.5 хувьтай байна. Цаашид эмч, эмнэлгийн мэргэжилтний хангалтыг нэмэгдүүлэх, чадавхжуулах зорилгоор аймгийн хэмжээнд нэн шаардлагатай эмнэлгийн мэргэжилтнүүдийг суралцуулах саналыг Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлж, "Хамтын ажиллагаатай Булганчууд 2022" арга хэмжээний хүрээнд Бүгд Найрамдах Солонгос Улстай хамтын ажиллагаа өргөжүүлэх хамтран ажиллах гэрээ байгуулж, олон улсын түвшинд нэвтэрч байгаа эмчилгээ, оношилгооны орчин үеийн аргын талаар мэдлэгтэй болох нөхцөл бүрдсэн. Мөн Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль болон Этүгэн их сургуультай "Хамтран ажиллах гэрээ"-г байгуулан, орон нутагт ажиллах 2 сувилагчийг элсүүлсэн.</p> <p>Шүд, эрүү нүүрний мэс заслын эмчилгээний чиглэлээр "Моза Дент" шүдний эмнэлгийн Нүүр ам судлалын их эмч БНСУ-ын Бусан, Дэгү хотод "Domg-A "их сургуулийн багш нар болон "Арек" эмнэлгийн шүдний тасгийн эрхлэгч, багш нарын хамтарсан "Шүдний имплант суулгалт" сэдэвт онол, гардан үйлдлийн сургалтад хамрагдсан. Мөн Эрүүл мэндийн газрын сувилахуйн мэргэжилтэн БНХАУ-ын Хунань мужийн хүүхдийн эмнэлгээс зохион байгуулж буй "Яаралтай тусламжийн сувилахуй" цахим сургалтад хамрагдсан. "Эрүүл мэнд" хөтөлбөрийн 3.0 сая төгрөгийн хөрөнгөөр аймгийн Эрүүл мэндийн газрын 2 мэргэжилтнийг төрөлжсөн мэргэжил олгох сургалтад хамрууллаа.</p> <p>Хишиг-Өндөр суманд төрийн албан хаагчдын 60 айлын орон сууцны төсөл хэрэгжүүлэхээр болж, энэ онд барилгын зураг төсөв нь хийгдэж, барилга барих газрыг сумын ИТХ-ын хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн.</p>	75.0
1.1.7	Эх, хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан өвчлөл, эндэгдлийг бууруулна.	<p>Эх, хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор улсын төсвийн 64.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн төрөх эмэгтэйчүүдийн тасагт функциональ ор, ургийн хяналтын монитор, инкубатор, сэхээн амьдруулах ширээ, тариурын автомат шахуурга /памп/, ургийн доплероор аппаратаар хангаж, төрийн бус байгууллага, иргэдийн санаачилгаар эхийн амрах байрыг засварлан тохижуулж, алслагдсан сумаас ирсэн эхчүүдийг тав тухтай орчинд байрлаж, эмнэлгийн тусламж авах нөхцөлийг бүрдүүлсэн байна. "Эрүүл мэнд" хөтөлбөрийн зорилтод тусгагдсан нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийг 8 суманд зохион байгуулж, 2123 эмэгтэйг үзлэгт, 800 эмэгтэйг "Нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт"-ийн сургалтад хамруулснаар умайн хавдар, өндгөвчний уйланхай, цөс, бөөрний чулуутай зэрэг өвчний тохиолдол 111 илэрснийг төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгүүдэд шилжүүлэн, оношийг тодруулан хяналтад авч, эмчилгээ хийсэн. Дээрх арга хэмжээнүүдийн үр дүнд эх, хүүхдэд эмнэлгийн тусламж үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт сайжирч, ээлтэй орчин бүрдэн эмэгтэйчүүдийн дунд зонхилон тохиолдох өвчин эмгэгийн эрт илрүүлгийн үзлэгийн чанар, хүртээмж сайжирсан.</p>	85.0
1.1.8	Нүхэн 00-той эмнэлгийг үе шаттайгаар орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгоно.	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 19 эрүүл мэндийн байгууллага 16 төвлөрсөн ариун цэврийн байгууламж ашиглаж байна. 2023 онд шинээр ашиглалтад орох Дашинчилэн, Орхон сумын Эрүүл мэндийн төвийн барилгын зураг төсөвт ариун цэврийн өрөөтэй байхаар тусгасан.	30.0
1.2. Боловсрол. Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, төлөвшил, гэр бүлийн амьдралын баталгаа, орон нутгийн хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцах тогтолцоог бэхжүүлнэ.			

1.2.1	Суралцагчийг бие даан, бүтээлчээр суралцахууд сургах боломж олгох, тэдний авьяас, ур чадварыг хөгжүүлэх, хүмүүжил, төлөвшил, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, амьдрах ухаанд суралцуулах бодлого баримтлан ажиллана.	Сургалтын орчныг сайжруулах, сурагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор нийт давхардсан тоогоор ерөнхий боловсролын 21 сургуульд 361.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, "Тогтвортой хөгжлийн боловсрол 2" төслийн хүрээнд Булган сумын "Эрдмийн Өргөө" цогцолбор сургуульд "Эко номын сан", Могод сумын сургуульд "Цахим танхим", Хишиг-Өндөр сумын сургуульд "Ногоон оффис", Хялганат тосгоны сургууль "Эко зуслан" төслийг 80.0 сая төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлэв. "Шинэ ирээдүй" хөтөлбөрийн хүрээнд лектор болон ментор багш нар, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж, 80 гаруй сургалт, нөлөөллийн арга хэмжээ, гүйцэтгэл оношлох үнэлгээ зэрэг томоохон арга хэмжээнүүдэд давхардсан тоогоор 17974 хүүхдийг хамрууллаа. Боловсролын үнэлгээний төвтэй хамтран II-XII ангийн сурагчдыг оношлох үнэлгээг судлагдахуун бүрээр хийж, мэргэжлийн 68 багштай баг байгуулан зөвлөмж боловсруулж, бүх сургуульд хүргүүлсэн. Бага ангийн монгол хэлний үнэлгээ 7.7 хувь, дунд ангийн монгол хэлний үнэлгээ 8.0 хувь, ахлах ангийн үнэлгээ 6.4 хувиар тус тус ахисан бол 12 дугаар ангийн сурагчдын сургуульд суурилсан үнэлгээгээр нийгмийн ухааны хичээлүүдэд /монгол хэл, нийгмийн ухаан/ 1-3 хувь ахиц гарсан байна. Насан туршийн боловсролын төв болон их дээд сургууль, мэргэжлийн байгууллагуудтай хамтран "Мэргэжил сонголт-Амжилтын үндэс" сургалт, өдөрлөгийг 2-9 дүгээр ангийн сурагч нарт 2-5 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 3500 гаруй хүүхдийг хамрууллаа. Хүүхэд хамгааллын чиглэлээр 40 гаруй төрлийн сургалт, үйл ажиллагаанд 8-12 дугаар ангийн 4000 гаруй хүүхэд, багш нарыг оролцуулсан нь өмнөх оноос 85.0 хувиар ахисан, сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа өмнөх оноос 16.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мөн аймгийн Засаг даргын нэрэмжит тэтгэлэг хөтөлбөрт 63 оюутанд 244.0 сая төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг тусалцаа үзүүлсэн нь өмнөх оноос 48.0 хувиар ахисан үзүүлэлттэй байна.	81.7
1.2.2	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургууль, цэцэрлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлж, сэргээн засах үйлчилгээг нийгэм, хамт олонд нь түшиглэн тогтмол үзүүлнэ.	2022-2023 оны хичээлийн жилд 43 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэгт тэгш хамруулах зорилгоор цэцэрлэгийн 22 багшийг үндэсний хэмжээний сургалтад хамруулж, 10 дугаар сард Дэлхийн банкны санхүүжилтээр зохион байгуулагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй" сэдэвт цахим сургалтад цэцэрлэгийн 15 багш, ерөнхий боловсролын сургуулийн 21 багш хамрагдлаа. Аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын сургуульд 75, сургуулийн өмнөх боловсролд 19, албан бус хөтөлбөрөөр 14 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, нийт 108 хүүхэд суралцаж байна. Энэ нь 2022 оны жилийн эцсийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хамран сургалт суурь түвшнээс 27.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	100
1.2.3	Цахим сургалтын платформыг хөгжүүлж, цахим агуулга, цахим хичээл боловсруулж, бүх насны иргэдийн "Насан туршийн боловсрол"-ыг дэмжинэ.	Цахим сургалтын платформыг хөгжүүлж, цахим агуулга, цахим хичээл боловсруулж, бүх насны иргэдийн "Насан туршийн боловсрол"-ыг дэмжих зорилтын хүрээнд 400.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийж, ерөнхий боловсролын 20 сургуульд математикийн кабинет тохижуулахад 200.0 сая, ерөнхий боловсролын 11 сургууль болон Боловсрол, шинжлэх ухааны газрын "Багшийн хөгжлийн төв"-д 157.0 сая төгрөгөөр ухаалаг дэлгэц, ерөнхий боловсролын 3 сургуульд "Студийн тоног төхөөрөмж"-д 57.0 сая төгрөг тус тус зарцуулан, Боловсролын үнэлгээний төвтэй хамтран нээлттэй даалгаврын сангийн системд энэ онд 7050 даалгавар боловсруулан оруулж байна. "Ээлжит хичээлийн цахим контентын сан"-д 282 цагийн хичээл байршуулан, Боловсрол, шинжлэх ухааны газрын албан ёсны вэб сайтад багш нарын цахим хичээл байршуулах ажил хийгдэж, боловсролын динамик сайт, цахим платформтой холбож өгсөн. Ерөнхий боловсролын сургуулиуд asky.mn болон үнэлгээний даалгаврын нэгдсэн сангийн iteambank.eec.mn цахим системийг ашиглах гэрээг хийж, Могод, Рашаант, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сумын ерөнхий боловсролын сургууль "Амжилт-2.0" системийг нэвтрүүлэн ажиллалаа. Үүний үр дүнд багш нарын цахим орчин нөхцөлд ажиллах боломж, чадвар 12.0 хувиар, гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмж 23.0 хувиар ахисан амжилттай байна. Насан туршийн боловсролын төв болон сумдын нэгжийн багш нар 2022 оны жилийн эцсийн байдлаар насан туршийн боловсролын сургалтын үндсэн агуулгаар танхимын болон танхимын бус 851 удаагийн сургалт явуулж, 28972 иргэнийг хамруулсан бөгөөд энэ нь зорилтот хүн амын 46.7 хувийг хамруулсан нь өмнөх оноос 14.0 пунктээр ахисан үзүүлэлттэй байна.	95.0

1.2.4	Багшлах боловсон хүчний мэргэжил, арга зүйн хөгжлийг дэмжиж, тэднийг урамшуулах, харилцан туршлага солилцох боломжийг олгож, нийгмийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэхэд анхаарна.	"Шинэ багш" хөтөлбөрийн хүрээнд 4 зорилтын 22 арга хэмжээг хэрэгжүүлж, "Сургуульд суурилсан менежментийн загвар"-ыг хэрэгжүүлэн зорилтот 4 модулийн 223 төрлийн цахим болон танхимын сургалт, уулзалтанд давхардсан тоогоор 52284 багш, удирдах ажилтныг хамруулан 114.4 сая төгрөгийг зарцуулаа. Тухайлбал: "Багш солилцоо" хөтөлбөрөөр 10 байгууллагын 16 хүн арга зүй, туршлагаа солилцож, 195 судалгаат хичээлийг зохион байгуулсан. Багшлах хүний нөөц, нөхөн хангалтыг сайжруулахаар "БАТЛАМЖ" шалгалтыг зохион байгуулж багш нарын ахиц, амжилтын судалгаа өмнөх оноос 4.0 хувиар ахисан ба 68.0 хувь нь 3-6 дугаар түвшний мэдлэгтэй байна. Судлагдахуун тус бүрийн мэргэжил дээшлүүлэх сургалтуудад 19 чиглэлээр 2272 багш, удирдах ажилтныг хамруулж ажилласан. Хөтөлбөрийн хүрээнд нийт багш нарын 80.0 хувь нь "Багш хөгжлийн төлөвлөгөө"-тэй ажиллаж, "Зөвлөх" зэрэгтэй багш 3-аар нэмэгдэн 12 болж, өмнөх оноос 38.0 хувиар, "Тэргүүлэх" зэрэгтэй багш 125 буюу 52.0 хувиар, магистр зэрэгтэй багш 74 буюу 9.2 хувиар тус тус өссөн байна. Үүний үр дүнд улсын илтгэлийн уралдаанд 6 дугаар байр, Нийгмийн тухай мэдлэгийн улсын эсээ бичлэгийн уралдаанд тэргүүн байр эзэлж, улсын төрөлжсөн олимпиадаас 3, 6, 13 дугаар байранд шалгарсан амжилт үзүүлээд байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт 2022 оны жилийн эцсийн байдлаар 84.5 хувьтай байна. Мөн 2022 оны 9 дүгээр сараас эхлэн TESOL мэргэжлийн англи хэлний багш Шериф Смайлтай хамтран англи хэлний 35 багшийг сургалтад тогтмол цахимаар болон танхимаар хамруулан ярих, бичих, сонсох, унших чадварыг хөгжүүлэх, "Англи хэл сурч хамтдаа хөгжье" сарын аяны хүрээнд иргэд, төрийн албан хаагчдад ярианы клуб, анхан шатны сургалт зохион байгуулан ажиллаж, 15.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, шаардлагатай материаллаг баазыг хангаж ажиллалаа.	80.0
1.2.5	Багш, сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулж, боловсролын байгууллагуудад шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар шийдвэрлэх замаар боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, "Хүүхдэд ээлтэй" сургалтын орчин нөхцөлийг бүрдүүлнэ.	Бага боловсролын сургалтын орчныг сайжруулах чиглэлээр Боловсрол шинжлэх ухааны яам, Дэлхийн банкны хамтарсан "Боловсролын чанарын шинэчлэл" төслөөс 9 сургуульд 74.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. 2021-2022 оны хичээлийн жилийн хөрөнгө оруулалтаас харахад цэцэрлэг, сургуулийн тоног төхөөрөмж, тоглоом тохижилтын ажил хангалттай сайн хийгдсэн ба өмнөх оноос 52.4 хувиар ахисан байна. Цэцэрлэгийн өргөтгөл, шинэ барилга өмнөх оноос 36.0 хувиар, их засвар 37.7 хувиар буурч, тоног төхөөрөмж 21.0 хувиар нэмэгджээ. Мэдээллийн технологийн хөгжилтэй уялдуулан цахим платформуудыг үе шаттайгаар нэвтрүүлэх, багш нарын цахим орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 20 сургуульд математикийн кабинет авахад 200.0 сая, ерөнхий боловсролын 11 сургууль болон Боловсрол, шинжлэх ухааны газрын "Багшийн хөгжлийн төв"-д 157.0 сая төгрөгөөр ухаалаг дэлгэц, ерөнхий боловсролын 3 сургуульд "Студийн тоног төхөөрөмж"-д 57.0 сая төгрөгөөр тус тус авсан. Боловсрол шинжлэх ухааны яамны санхүүжилтээр Гурванбулаг сумын сургуульд хөгжмийн хичээлийн хэрэглэл, цахилгаан хөгжмийн иж бүрдэл 14.6 сая төгрөг, "Тогтвортой хөгжлийн боловсрол-2" төслөөр 4 сургуульд 120.0 сая, Швейцарын хөгжлийн агентлагийн "Эко кабинет байгуулах" төслөөр 3 сургуульд 36.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтууд тус тус хийгджээ. Мөн Баяннуур, Дашинчилэн, Могод, Булган сумын 1, 3 дугаар сургууль, Спортын дунд сургууль, Эрдмийн Өргөө цогцолбор сургуульд нэн шаардлагатай байгаа биеийн тамирын хичээлийн хэрэглэгдэхүүнийг Боловсрол шинжлэх ухааны яамны хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлэхээр боллоо. Зуны цэцэрлэгийн 34 бүлэг ажиллаж 680 хүүхэд хамруулсан. Бугат суманд 2 шовгор цэцэрлэг, хоолны саравч барьж гүйцэтгэн орон нутгийн төсвөөс 3.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангав.	80.0
1.3. Биеийн тамир, спорт. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, амьдралын салшгүй хэсэг болгож, үндэсний болон өвөл, зуны спортуудыг дэмжиж, Булган аймгийн баг, тамирчдын улс, тив, дэлхийн түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.			
1.3.1	Хүн амыг идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр хичээллэх, эрүүл дадал хэвшилд сургах, орчин нөхцөлийг сайжруулах ажлыг төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааны үндсэн дээр хэрэгжүүлж, нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ.	Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэхэд шаардлагатай фитнесийн 11 төрлийн тоног төхөөрөмжийг орон нутгийн төсвийн 13.8 сая төгрөгөөр авч иргэдийн бие бялдрыг чийрэгжүүлэх спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэв. Тус хөрөнгө оруулалтын дүнд сагсан бөмбөг, волейбол, ширээний теннис, бокс, самбо, жүдо бөхөөр хичээллэх хүүхдүүдэд сургалтын таатай орчин бүрдэж, фитнес танхимаар хичээллэгсдийн тоо нэмэгдэж, сард дунджаар давхардсан тоогоор 260 орчим хүн тогтмол хичээллэж байна.	65.0
1.3.2	Үндэсний спорт болон уламжлалт тоглоом наадгай, олимпын төрлийн спортуудыг бодлогоор дэмжиж, тамирчдын амжилтыг ахиулах, олон улс, улс, бүсийн чанартай уралдаан, тэмцээн зохион байгуулж, аймгийн өсвөрийн шигшээ багийг 12-оос доошгүй төрлөөр байгуулна.	2022 онд үндэсний спортын уралдаан тэмцээний хөрөнгө санхүүжилт 22.5 хувиар өсөж, улс, бүсийн тэмцээнийг 5 удаа зохион байгуулснаар үндэсний бөх, сур, шагайн спортоор аймгийн хэмжээнд 1500 орчим хүн тогтмол хичээллэж, амжилтын чанар дээшилж, улсын цолтой бөхчүүд, зэрэгтэй харваачдын тоо нэмэгдсэн. Аймгийн Засаг даргын 2022 оны А/203 дугаар захирамжаар өсвөрийн шигшээ багийг спортын 12 төрлөөр байгуулж тамирчид, багш дасгалжуулагчдыг сонгон шалгаруулан бэлтгэл сургуулилт тогтворжиж, 2022 онд 16 удаагийн улс, бүсийн чанартай тэмцээнд оролцож, 68 медаль хүртэж тамирчдын амжилт өмнөх оны мөн үеэс 23.0 хувиар ахисан байна.	100

1.3.3	Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандартын шаардлага хангасан талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, материаллаг баазыг бэхжүүлнэ.	2022 онд иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэхэд зориулагдсан гадаа талбай Баяннуур, Булган, Бүрэгхангай, Гурванбулаг, Рашаант, Хишиг-Өндөр суманд улсын төсвийн 250.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн. Мөн Бүрэгхангай суманд бөхийн заалыг хандив тусламжийн 200.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтанд орсноор иргэд биеийн тамир спортоор хичээллэх нөхцөл бүрдсэн.	90.0
1.3.4	Спортын сургалттай ерөнхий боловсролын сургуулийн хөгжлийн стратеги төлөвлөгөөг шинээр баталж, хэрэгжүүлнэ.	Спортын дунд сургуулийн тусгай хөтөлбөр боловсруулж, багш, дасгалжуулагчдын ур чадварын сайжруулах зорилгоор Монголын үндэсний олимпын хороо, Олимпын академиас зохион байгуулсан арга зүйн сургалтад бөх, хөнгөн атлетик, тэшүүр, буудлага, бокс гэсэн 5 төрөлд 5 багш, дасгалжуулагчийг хамруулж, биеийн тамир спорт, олимпын хөдөлгөөний түүх ба хөгжил сэдэвт сургалтад спортын холбоодын төлөөлөл, биеийн тамирын багш нарыг хамруулж, мэдлэг, ур чадварыг сайжруулсан. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэхэд шаардлагатай 14.3 сая тоног төхөөрөмжийг хүлээн авч суурилуулан, сургалтын орчин нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.	80.0
1.3.5	Биеийн тамир, спортыг хөгжүүлэх аймгийн хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж, гадаад харилцааг бэхжүүлнэ.	Биеийн тамир, спортыг хөгжүүлэх 2021-2023 оны төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 20 арга хэмжээ хэрэгжүүлэн ажилласнаар жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 77.4 хувьтай байна. Тус хөтөлбөрийн хүрээнд "Илүүдэл жингүй-Эртэч Монгол" аянд 38000 гаруй ажилтан албан хаагч, "Иргэдийн спортын наадам"-ыг спортын 4 төрлөөр зохион байгуулж 16 сум, байгууллагын 300 гаруй тамирчид, Ардын багш Х.Алтанхуягийн нэрэмжит Боксын Залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнийг аймагтаа зохион байгуулж, 33 багийн 226 тамирчин оролцож, спортоор хичээллэгсдийн тоо нэмэгдэж, тамирчдын амжилт дээшилсэн. Мөн аймгийн хэмжээнд 54 төрлийн секц дугуйланд 2780 хүүхэд хамрагдаж, 63 багш дасгалжуулагч ажилласнаар улс, бүс, аймгийн чанартай уралдаан тэмцээнд оролцогсдын тоо өмнөх жилүүдээс 20-30 хувиар нэмэгдэж, үзүүлсэн амжилтын дүнгээр улсын хэмжээнд 4-р байрт жагсаж байна.	70.0
1.4.Соёл, урлаг. Соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг өргөжүүлж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ үндэсний өв уламжлалыг залгамжилж, орчин үеийн соёл урлагийн чиг хандлагатай хослуулан хөгжүүлнэ.			
1.4.1	Анхдагч түмний бахархал, монгол өв соёлыг хойч үедээ өвлүүлэх, орчин үеийн соёл урлагийг түгээн дэлгэрүүлэх замаар соёл урлагийн тогтвортой хөгжлийг хангана.	"Бүх нийтийн соёлын боловсрол олгох 2022 оны төлөвлөгөө"-ний дагуу 19 арга хэмжээг 20.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж, жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 83.6 хувьтай байна. Тус хөтөлбөрийн хүрээнд аймгийн соёл, урлагийн өдрүүд, "Булган хангайн хүүхдүүд" урлагийн наадам, "Хангинахын шугуйн шагайн тойром", "Эмч нартаа баярлаллаа" сарын аян зэрэг томоохон арга хэмжээнүүдийг зохион байгуулж, давхардсан тоогоор 20 гаруй мянган иргэдэд хүргэж ажилласан. Тухайлбал: "Булган хангай" хүүхдийн урлагийн наадмыг 13.6 сая төгрөгийн санхүүжилтээр зохион байгуулж, 1211 хүүхдийг хамруулан төгсөх ангийн шилдэг 5 сурагчид МУ-ын Консерваторт суралцах батламж, аймгийн Засаг даргын тэтгэлгээр шагнаж урамшууллаа. Соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор 15.0 сая төгрөгийн өртөгөөр 3 контент бэлтгэн улс орон даяар сурталчилсан. Аймгийн Хөгжимт жүжгийн театр, Орхон аймгийн "Эрдэнэт" дуу бүжгийн чуулгын дуучдын "Монголоо дууля" концерт болон "Урлан бүжихүй" бүжгийн бүрэн хэмжээний хамтарсан тоглолтыг зохион байгуулж, тоглолтод 58 уран бүтээлч оролцон 2.0 сая төгрөг зарцуулан хоёр аймгийн иргэдэд 4 удаа толилуулан, 1500 гаруй үзэгчдэд хүргэсэн. Монголын Үндэсний номын сан, Орхон аймгийн номын сантай хамтран улсын төсвийн 7.3 сая төгрөгийн санхүүжилтээр орон нутгийн номын санчдын ур чадварын уралдааныг зохион байгуулж, 45 номын санч ур чадвараа сорин өрсөлдөж, чадавхжуулах сургалтад хамрагдсан. Хамтын ажиллагааны хүрээнд уран бүтээлчдийн ур чадвар нэмэгдэж, уран бүтээлийн чанарт ахиц гарч үзэгч, үйлчлүүлэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 10.0-15.0 хувиар нэмэгдсэн байна.	92.5

1.4.2	Аймгийн Хөгжимт жүжгийн театрын барилгыг шинээр барьж, соёлын төвүүдийн барилгыг үе шаттай засварлан, салбарын материаллаг баазыг сайжруулна.	Соёлын өвийг хадгалах, түгээн дэлгэрүүлэхэд нэн шаардлагатай аймгийн Музейн барилгын өргөтгөлийн зураг төсвийг хийж, газрын асуудлыг шийдвэрлэсэн. 2022 онд Бугат сумын 240 хүний суудалтай Соёлын төвийн барилгыг 300.0 сая төгрөгийн өртгөөр барьж байгаа бөгөөд барилгын ажлын гүйцэтгэл 30.0 хувьтай явагдаж байна. Сэлэнгэ сумын соёлын төвийн дээврийн засварыг орон нутгийн төсвийн 150.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Хурмастын хүлэг" ХХК хийж гүйцэтгэлээ. Баяннуур сумын соёлын төвийн засварын ажлыг орон нутгийн төсвөөс 199.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Густокек" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд барилгын ажил 60.0 хувьтай явагдаж байна. Тэшиг сумын соёлын төвийн их засварын ажлыг орон нутгийн хөгжлийн сангаас 15.0 сая төгрөгөөр "Дорнын цэнхэр тал" ХХК хийж гүйцэтгэлээ. Хутаг-Өндөр сумын соёлын төвийн их засварын ажлыг орон нутгийн хөгжлийн сангаас 46.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Хурмастын хүлэг" ХХК 1 дүгээр ээлжинд их заалны тайзны дээвэр, номын сангийн тааз засварлан, "Баатар ван" амралт сувилалын газар нийгмийн хариуцлагын хүрээнд 30.0 сая төгрөгөөр их заалны шалны ажлыг гүйцэтгэлээ. 2022 онд аймгийн соёл урлагийн байгууллагын техник хэрэгсэл, материалыг үе шаттай шинэчлэх зорилгоор улсын төсвийн 60.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хөгжимт жүжгийн театрт лед дэлгэц, 175.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн Музей, Төв номын сан, Булган сумын соёлын ордон, 12 сумын соёлын төвд хөгжим, камер, тоног төхөөрөмж нийлүүлсэн. Сум хөгжүүлэх сангийн 56.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Бүрэгхангай, Дашинчилэн, Могод, Рашаант суманд караоке төхөөрөмж, проектор, дэлгэц, өсгөгч, компьютер авч материаллаг баазыг нэмэгдүүлээ. Дээрх арга хэмжээний үр дүнд сумын соёлын төвүүдийн техник тоног төхөөрөмжийн хангалт 75.0 хувьд хүрч иргэд олон нийтэд соёлын үйлчилгээг чанартай, саадгүй хүргэх нөхцөл боломж бүрдэж байна.	80.0
1.4.3	Аймгийн соёл урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг аялал жуулчлалтай холбон хөгжүүлж, урлаг, соёл, аялал жуулчлалын "Эвент" үйл ажиллагааг зохион байгуулна.	ОХУ-ын Буриад улсын Агын тойрогт зохион байгуулагдсан "Алтаргана 2020" олон улсын Буриадын XIV их наадамд Булган аймгаас 50 хүний бүрэлдэхүүнтэйгээр оролцож, 46.0 сая төгрөгийг зарцууллаа. Тус наадмын спорт, урлагийн 8 төрөлд 32 тамирчин, багш, дасгалжуулагчдын хамт амжилттай оролцов. Энэхүү арга хэмжээний хүрээнд аймгийн удирдлагууд Буриадын Агын тойргийн удирдлагуудтай ажил хэргийн уулзалт зохион байгуулж, 2024 онд Булган аймагт Алтаргана-2024 наадмыг зохион байгуулах эрхийг авч, наадмын хаалтын ажиллагааны үеэр Алтарганы тугийг хүлээн авсан. "Айраг наадам 2022" эвент арга хэмжээний хүрээнд 7 төрлийн /дэмбээ, сээр шалгах, багийн хуруу, шагай шүүрэх, оньс ээдрээ тайлах, 32 цагаан лонх, 25 хул тоолох/ тэмцээн уралдаан зохион байгуулж, Улаанбаатар хот, төвийн бүсийн 4 аймаг, Булган аймгийн 13 сумын 300 гаруй оролцогчид өрсөлдсөн байна. Арга хэмжээний хүрээнд 7.2 сая төгрөгийг зарцуулан аймгийн төв Номын сангаас адуу, айраг уламжлалт соёлын тухай номоор үзэсгэлэн гаргаж 68 хүн, аймгийн Музей адууны соёлтой холбоотой 9 дэсийн 28 ширхэг үзмэрээр явуулын үзэсгэлэн гаргаж, Хөгжимт жүжгийн театр талбайн нээлт, хаалтад соёл урлагийн арга хэмжээг зохион байгуулж, 16000 гаруй иргэнд хүргэсэн байна.	100
1.4.4	Орон нутгийн соёлын байгууллагууд, иргэн, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын оролцоонд суурилан соёлын өвийг хамгаалалтад авах, соёлын биет болон биет бус өвийн оршин тогтнох чадавхыг бэхжүүлж, цахим соёлын санг бүрдүүлнэ.	Булган сумын хэмжээнд шилдэг 8 өвлөн уламжлагчийг журмын дагуу сонгож, аймгийн Хөгжимт жүжгийн театрт тайлбарт концерт тоглож, 8 өвлөн уламжлагчийг улсын төсвөөс 527.0 мянган төгрөгийн дурсгалын зүйлээр урамшуулсан. Мөн 11 дүгээр сард Соёлын бүтээлч сарын аяны хүрээнд аймгийн хэмжээнд 5 шилдэг өвлөн уламжлагчийг орон нутгийн төсвийн 1.5 сая төгрөгөөр шагнаж урамшууллаа. Соёлын биет бус өв тээгчдийн бүртгэлийн ich.mongoluv.mn шинэ системийг нэвтрүүлэн 2022 оны жилийн эцсийн байдлаар 3 суманд биет бус өв тээгч 12 хүний мэдээллийг шинээр бүртгэн баримтжуулав. Соёлын биет бус өвийг өвлүүлэх зорилгоор уртын дууг 54, морин хуурыг 36, гар урлалыг 34, шагай харваа 10 хүнийг тус тус сургаж, өвлөн уламжлагч нарын сургалтыг зохион байгуулан ерөнхий боловсролын сургуулийн 7-10 дугаар ангийн 321 сурагчийг хамруулсан. Соёлын биет өвийн rich.mongoluv.mn мэдээллийн сангийн мэдээллийг шинэчлэх тооллогын ажил 80.0 хувьтай хийгдэж, улс, аймгийн хамгаалалттай 53 дурсгалаас 21 дурсгалыг орон нутгийн хүмүүстэй хамтран ажиллах гэрээ байгуулан эзэнжүүлэн хамгаалалттай болгов. "Аймгийн түүх соёлын үл хөдлөх дурсгалын судалгааны түүхэн тойм" сэдвээр судалгааны ажил хийж, олон нийтэд цахимаар сурталчлах ажлыг зохион байгуулж, түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт "Хүйс толгойн бичээс" бүхий гэрэлт хөшөөг залах ёслолыг Могод суманд зохион байгуулж ажиллалаа.	100

1.4.5	Түүх соёлын үл хөдлөх дурсгалт газруудыг аялал жуулчлалын төв болгон хөгжүүлнэ.	“Цогт тайжийн Цагаан байшин” дурсгалыг хашаажуулах ажил орон нутгийн төсвийн 79.0 сая төгрөгөөр хийгдэж, Авто-рали уралдааны нээлтийг Цогтын цагаан байшин орчим газарт зохион байгуулж, жуулчдад зориулсан түүхийн дурсгалт газруудын гарын авлагыг 300 хүнд тараан сурталчиллаа. Дашинчилэн сумын Хар бухын музейд дээвэр дотор засалт, хашааны ажлыг гүйцэтгүүлэн хүлээн авч, Шороон бумбагар бунхант булшны хадгалалт, хамгаалалт, сэргээн засварлалтын талаар Соёлын яам болон ТИКА олон улсын байгууллагад албан бичиг хүргүүлсэн. Баруун замын байлдааны штаб музейн их засварыг 117.0 сая төгрөгийн санхүүжилтээр "Он тэнгэрийн бичиг" ХХК, Хатанбаатар Магсаржавын "Дуулгат бунхан"-г сэргээн засварлах ажлыг 300.0 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэв. Булган сумын хэмжээнд түүхэн дурсгалт газрын аяллын маршрут гаргаж өртөөчилсөн хэлбэрээр ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад дурсгалт газартай танилцах явган аяллыг жилд 1-2 удаа зохион байгуулж байна.	100
1.4.6	Соёл урлагийн салбарын мэргэжилтэй боловсон хүчнийг орон нутгийн бодлогоор бэлтгэж, мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулж, тэднийг тогтвор суурьшилтай ажиллуулахад анхаарч, нийгмийн асуудлыг шийдвэрлэх бодлого баримтална.	Соёл Урлагийн Их сургууль, Монгол Улсын Консерваторитай хамтран элсэлтийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, 25 хүүхдэд элсэн суралцах урилга гардуулсан. Мөн 5 сурагчид аймгийн Засаг даргын нэрэмжит 1 жилийн сургалтын төлбөрийн тэтгэлэг олгов. Соёл Урлагийн Их сургуулиас зохион байгуулсан 5 багц сургалт, Соёл урлагийн газраас зохион байгуулсан 6 чиглэлийн сургалт, Соёлын яам, Соёлын өвийн үндэсний төвөөс зохион байгуулсан 12 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 320 ажилтан, албан хаагч хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүлсэн. Булган аймгийн соёлын салбар дахь 162 албан хаагчаас 94 хүн мэргэжлийн, 68 хүн мэргэжлийн бус байна. Жилийн эцсийн байдлаар мэргэжлийн хүний нөөцийн хангалт 58.0 хувьтай байна.	71.4
1.5.Хөдөлмөр эрхлэлт. Орон нутгийн бизнес эрхлэгчид, хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, шинээр бий болсон ажлын байрыг тогтвортой хадгалж, өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.			
1.5.1	Аймгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгааг үндэслэн орон нутгийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд хөтөлбөр хэрэгжүүлж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлнэ.	Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгааг "Бүргэд" төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан гүйцэтгүүлж, мэдээлэл цуглуулалтыг түүврийн аргаар 1818 нэгжээс авсан. Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээрийг 13 суманд байгуулж, хэлэлцээрт заагдсаны дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны хүрээнд эрүүл мэндийн салбарт хамтарсан үзлэг шалгалтын ажлыг явуулж, үзлэгээр илэрсэн зөрчлийг арилгуулах хугацаатай үүрэг даалгавар өгсөн. Мөн 3 талын төлөөллийг чадавхжуулах сургалтыг 4 дүгээр сард цахимаар зохион байгуулж, сумдын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийн 87 гишүүнийг хамруулан мэдлэг, мэдээллээр хангав. Эдгээр арга хэмжээний үр дүнд жилийн эцсийн байдлаар Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн 3 талт хэлэлцээрийн хэрэгжилт 93.0 хувьтай байна. Хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор аймгаас 15.0 сая төгрөг зарцууллаа. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний дүнд ажил хөдөлмөр эрхлээгүй 742 иргэнийг ажлын байранд зуучилснаас байнгын ажлын байранд 300, улирлын ажлын байранд 92, түр ажлын байранд 350 иргэнийг зуучилсан. Ажилгүйдлийн түвшин 8.0 хувьтай байна. Төрийн байгууллагаас иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор 2022 онд "Бүтээмж-чанарыг сайжруулах жил"-ийн аяныг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, 30 удаагийн сургалтаар давхардсан тоогоор 1164 ажилтан, албан хаагчийг мэдлэг мэдээллээр хангалаа. Мөн тус аяны хүрээнд ажлын байрны дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтын судалгаанд 16 сумын 29 төрийн байгууллага, 2 төрийн өмчит компанийн 1099 ажилтан, албан хаагчийг хамруулсан ба төрийн байгууллагын 90 гаруй хувь нь бүтээмжийн хөдөлгөөн өрнүүлсэн байна.	90.0

1.5.2	<p>“Мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж, багш, суралцагсдын ажиллах, сурах орчин нөхцөлийг сайжруулж, МСҮТ-үүдийн сургалтын тоног төхөөрөмжийг шинэчлэх, засварлах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран үе шаттайгаар шийдвэрлэнэ.</p>	<p>Булган аймаг дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв болон Хөдөө аж ахуйн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд мэргэжлийн 53 багш ажиллаж, 30 гаруй мэргэжлээр мэргэжилтэй ажилтан бэлтгэж байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжүүлж байгаа 15-34 насны шинэ залуу хүний нөөцийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, төсөл хөтөлбөрт хамруулах зорилгоор залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох Старт-ап арга хэмжээнд 6 багийн 23 оролцогч хамрагдаж, бизнесийн шинэ санаагаар өрсөлдсөн. Тус арга хэмжээний хүрээнд 2 шатны шалгуур хангасан багт эргэн төлөх нөхцөлгүй 10.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн байнгын 2 ажлын байр шинээр бий болголоо. Мөн улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй "Оролцоо" төсөлд хамрагдах хүсэлтэй 18-34 насны залуусыг цахимаар бүртгэж, 27 залуу хамрагдаж, 8 иргэн байнгын ажлын байртай болов.</p> <p>Хөдөө аж ахуйн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв энэ хичээлийн жилд "Монгол ногоо" төслийн хүрээнд хүлэмжийн аж ахуйн фермер мэргэжлийн дадлагын газар болон өвлийн хүлэмжийг 6.0 сая төгрөгийн хөрөнгөөр ашиглалтад оруулан үйлдвэрлэлийн сургалтыг улирлаас үл хамааран явуулж байна. Булган хангай Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв 2021-2022 оны хичээлийн жилд мэргэжлийн ангиудын засвар үйлчилгээг үе шаттайгаар хийж онол, дадлагын байрыг нэг дор төвлөрүүлэн шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг авсан. Мөн Туркийн хамтын ажиллагааны агентлаг /ТИКА/ болон Япон улсын "Өвсний үндэс" хөтөлбөрийн төслийн газарт үйлдвэрлэлийн дадлагын орчныг шинээр барьж байгуулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах төслийг хүргүүлэв.</p> <p>Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийн сургалтын орчныг сайжруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, сургалтын орчин, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлснээр оюутан сурагчид улирлаас үл хамааран дадлага хийх боломж бүрдэж, сургуулиудын сургалтын чанар 20.0 хувиар дээшилж, суралцагчдын сэтгэл ханамж нэмэгдэж байна.</p>	100
1.5.3	<p>Өрхийн үйлдвэрлэл болон хувиараа хөдөлмөр эрхлэх сонирхол, боломжтой иргэдийг дэмжиж зээлэнд хамруулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, ажлын байранд зуучлах замаар 5000-аас доошгүй ажлын байр бий болгоно.</p>	<p>Булган суманд “Намрын ногоон өдрүүд-2022” хөдөлмөрийн яармаг, үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 19 иргэн, 6 аж ахуйн нэгж, байгууллагын 40 нэр төрлийн бүтээгдэхүүн оролцсоны зэрэгцээ “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд 12 иргэн 16 нэр төрлийн модны тарьц суулгац худалдан борлуулсан байна. Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулах, сурталчлах зорилгоор “Булганд үйлдвэрлэв” борлуулалтын цэгийг Хутаг-Өндөр суманд шинээр байгуулав. Улаанбаатар хотод “Хамтын ажиллагаатай Булганчууд” үзэсгэлэн худалдаанд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдсан 6 иргэн өөрсдийн үйлдвэрлэсэн айраг, цагаан идээ болон бусад бараа бүтээгдэхүүнээр оролцсон байна.</p> <p>2022 онд 1300 ажлын байр шинээр бий болгохоор төлөвлөснөөс давхардсан тоогоор 880 ажлын байрны захиалга авч “Сайхан Монгол” телевиз болон зарын цэгүүд, цахим хуудсанд байршуулан сурталчилж ажилласнаар 1250 шинэ ажлын байр бий болж, гүйцэтгэл 96.1 хувьтай байна. Мөн 742 иргэнийг ажилд зуучлахаар төлөвлөснөөс ажил олгогч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын сул чөлөөтэй ажлын байранд 742 иргэн зуучлагдаж, байнгын ажлын байранд 300, улирлын ажлын байранд 92, түр ажлын байранд 350 иргэн ажиллаж, гүйцэтгэл 100 хувьтай байна.</p> <p>Хувиараа хөдөлмөр эрхлэгч 104 иргэнд шаардлагатай тоног төхөөрөмж авах, ажлын байраа өргөтгөхөд нь зориулж 749.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон. Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний орлого 100.0-200.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, 26 шинэ ажлын байр бий болсон байна. Аймгийн цөөн малтай малчин өрхийг дэмжих арга хэмжээний хүрээнд 2 өрхөд 10.0 сая төгрөгийн, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн Малчин өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд 40 өрхөд 200.0 сая төгрөгийн нийт 2071 толгой мал худалдан авч өгч, 84 байнгын ажлын байрыг дэмжсэн. 2021 онд аймгийн малжуулах хөтөлбөрт хамрагдсан иргэдийн эргэн төлөлтөд 18.0 хувь буюу 25.0 сая төгрөгийг төрийн санд төвлөрүүлээд байна.</p>	97.5
<p>1.6.Нийгмийн хамгаалал. Нийгмийн зорилтот бүлгийн иргэдэд үзүүлэх нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээг гэр бүлд төвлөрүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настны болон хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах, жендэрийн тэгш байдлыг хангах, тэдний нийгмийн идэвх оролцоог дэмжсэн хөгжлийн төвүүдийг бий болгож, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлнэ.</p>			

1.6.1	Аймгийн хэмжээнд гэр бүл, хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг дээдэлсэн, нийгмийн бүх бүлгийн оролцоог хангасан хүний хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангана.	Аймгийн засаг даргын нэрэмжит "Хүрч үйлчлэе" нийгмийн салбарын байгууллагуудын нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэн 8 сумын 2600 гаруй иргэнд үйлчилгээ үзүүллээ. Үүнээс гадна гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлуудыг үе шаттай зохион байгуулан ажилласнаар аймгийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн тоо өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 15.4 хувиар буурсан байна. Хүүхдийг эрсдэлээс урьдчилэн сэргийлэх, эцэг эхчүүдийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор "Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөл"-ийн анхдугаар зөвлөгөөнийг зохион байгуулж, 21 байгууллага хүүхдийн өрөө тохижуулан, бүх сургууль, цэцэрлэг хүүхэд хамгааллын бодлого, төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллаж байна. Залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлээр жилийн ажлын төлөвлөгөөг гарган модуль сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулж, сайн дурын залуучуудын клуб байгуулагдаж, салбар зөвлөлүүдийн үйл ажиллагаа эрчимжиж, 11359 залуу буюу нийт залуучуудын 65.4 хувьд хүрч ажилласан байна. Аймгийн "Ахмадын өргөө"-ний үйл ажиллагаа жигдэрч чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, мэдээ, мэдээллээр хангах төрөл бүрийн арга хэмжээг зохион байгуулж, ахмад настны өдрийн үйлчилгээнд 29, гэрийн асаргаанд 6, зөвлөх үйлчилгээнд 2 ахмад настан хамрагдсан ба харьяалалгүй 400 ахмад, 90-ээс дээш настай 83 ахмад настанд сар шинийн баярыг тохиолдуулан аймгийн Засаг даргын хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулж, 11.4 сая төгрөгийг зарцуулан 1520 ахмад настныг хамрууллаа. Мөн олон улсын ахмадын өдрийн хүрээнд олон төрлийн уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулж, 500 ахмад настанд нийт 28.0 сая төгрөгийн гарын бэлэг гардуулж хүндэтгэл үзүүлэв.	98.3
1.6.2	Хүн амын бүлгүүдийн хөгжил хамгааллыг сайжруулах зорилгоор хөгжлийн төвүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж, тэдний ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, шинээр барьж байгуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа 60 ортой сувиллын яслийн барилгын зураг төсвийг хийсэн. Аймгийн ахмадын өргөөний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, 25.0 сая төгрөгөөр шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, зарим засвар үйлчилгээг хийж гүйцэтгэв. Мөн ахмадын өргөөний 2 өрөөнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан гүйлтийн зам, ор, хөлний аппарат, өвдөгний аппарат, булчин суллагч зэрэг тоног төхөөрөмжийг 1.4 сая төгрөгөөр авсан. Хүүхдийн Жаргалант зуслангийн хоол, сургалтын танхим бүхий захиргаа удирдлагын байрны барилгын ажлыг улсын төсвийн 920.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Эко эрдэнэ үүр" ХХК гүйцэтгэн барилгын ажил 85.0 хувьтай байна. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 48.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Түр хамгаалах байрны барилгын сан техникийн холболтын ажлыг "Гурван Уулын хишиг" ХХК-иар гүйцэтгүүлж, улсын комисс хүлээн авсан. Тус байрны барилгын ажил дууссан бөгөөд 2023 оны 1 дүгээр улирлаас бүрэн ашиглана. Эдгээр бүтээн байгуулалтын үр дүнд хүн амын зорилтот бүлгийн иргэдийн ажиллах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцөл сайжирч, тэдний нийгмийн оролцоо нэмэгдэж байна.	84.0
1.6.3	Орон нутгийн түвшин дэх нийгмийн бүх харилцаанд жендэрийн тэгш байдлыг ханган ажиллана.	Орон нутгийн түвшин дэх нийгмийн бүх харилцаанд жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр 4 зорилтын хүрээнд 21 ажил төлөвлөж, төлөвлөгөөний биелэлт 90.3 хувьтай байна. Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан "Харилцан хүндэтгэе" аяныг зохион байгуулж, "Хүчирхийллийн эсрэг хүн бүр гэрэл асаая", "Нийгмийн хөгжилд эрэгтэйчүүдийн оролцоо манлайлал" хэлэлцүүлэг, Ханьдаа захидал бичээрэй захидлын уралдаан, АХА тэмцээн зэрэг үйл ажиллагааг зохион байгууллаа. "Нийгмийн хөгжилд эрэгтэйчүүдийн оролцоо манлайлал" хэлэлцүүлэгт төрийн байгууллагуудын удирдлага, эрэгтэй албан хаагчийн хамт 83 хүн оролцож, "Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд", "Эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт", "Эрэгтэйчүүдийн боловсрол", "Эрэгтэйчүүдийн оролцоо, нөлөөлөл" сэдвийн хүрээнд эрэгтэйчүүдэд тулгамдаж буй асуудлаар хэлэлцэж, гарсан саналуудыг улсын хэмжээний хэлэлцүүлэгт хүргүүллээ. Үүнээс гадна төрийн болон улс төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн манлайлал, нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор ЛЭОС болон аймгийн "Монгол хатад гэрэлтүүлэхүй" төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж байна. Тухайлбал: Эмэгтэйчүүдийн манлайллын сүлжээ арга хэмжээг хэрэгжүүлэн аймаг орон нутгийн улс төрийн болон төрийн албаны манлайлагч эмэгтэйчүүдийг татан оролцуулж, шийдвэр гаргах түвшний албан тушаалд горилох, улс төрийн сонгуульд нэр дэвших, улмаар иргэдийн итгэлийг хүлээн хүний эрхэд суурилсан, жендэрийн тэгш байдлын зарчимд нийцсэн, хамтын нөлөөллийн олон талт дэмжлэг үзүүлэх ажил арга хэмжээг зохион байгуулж байна.	100
ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО			
2.1. Эдийн засгийн тогтвортой хөгжил. Экологийн тэнцвэрт байдлыг хадгалсан, эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай, иргэдийн амьжиргааны түвшин өндөр, үндэсний хэмжээнд өрсөлдөх чадвар бүхий тэргүүлэгч аймгийн нэг болно.			
2.1.1	Эдийн засгийн хөгжлийн 2021-2024 оны үндсэн зорилтуудыг хэрэгжүүлж, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлнэ.	Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн 2021 оны гүйцэтгэлээр 485.2 тэрбум, нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн 7.8 сая төгрөгт хүрч дотоодын нийт бүтээгдэхүүн 21.5 хувиар, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 20.9 хувиар тус тус өссөн байна. Үүнээр хөдөө аж ахуйн салбар 14.6 хувь, үйлчилгээний салбар 7.8 хувийн өсөлттэй гарлаа.	100

2.1.2	Эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор гадаад, дотоод хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрийн хөрөнгийг тогтвортой нэмэгдүүлж, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ.	Тус зорилтын арга хэмжээг 2023 онд хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөгөөнд тусгасан.	-
2.1.3	Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжинэ.	Улсын төсвөөс эрх шилжиж ирсэн болон төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан 13.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 78 төсөл арга хэмжээнээс 75 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч шалгарч 12.6 тэрбум төгрөгийн гэрээг байгуулж ажилласан. Үүнээс 24 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчээр орон нутгийн аж ахуйн нэгж шалгарч, 3.7 тэрбум төгрөгийн гэрээт ажлыг гүйцэтгэсэн. Аймгийн Засаг даргын захирамжаар орон нутгийнхаа үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний салбарын тогтвортой үйл ажиллагааг хангах, ажлын байрыг хадгалж үлдэх, санхүүгийн эрсдэлээс сэргийлэхэд төрийн худалдан авалтаар дэмжлэг үзүүлэх чиглэлийн дагуу төр, төсвийн байгууллагууд хэрэгцээт бараа ажил үйлчилгээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд зохион байгуулж, 2022 онд 1779.8 сая төгрөгийн худалдан авалт хийсэн.	100
2.1.4	Татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар татварын үйлчилгээг иргэд, татвар төлөгчдөд хүндрэлгүй болгож, татварын бааз суурийг нэмэгдүүлнэ.	2021 оны жилийн эцсийн 16 төрлийн 46586 тайлан, 2022 оны 1 дүгээр улирлын 5 төрлийн 2116 тайланг цахимаар хүлээн авч баталгаажуулсан. Татвар төлөгч аж ахуйн нэгж 1835, иргэн 40796-д хүрсэн байна. Шинээр үүсэн байгуулагдсан 65 хуулийн этгээдийг татвар төлөгчөөр бүртгэж, 11 хуулийн этгээдийн бүртгэлийг шинэчилсэн. Хувь хүний орлогын албан татвар төлөгчөөр 184 иргэн, нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн болзол хангасан 32 татвар төлөгчийг татварын төрлөөр бүртгэж, 14 татвар төлөгчийг бүртгэлийн төрлөөс хассан. 2022 онд баазад бүртгэлтэй татвар төлөгчдийг 4 түвшинд ангилан, сургалт, сурталчилгааны 77 ажил арга хэмжээг төлөвлөн давхардсан тоогоор 152 удаагийн сургалтаар 2500 гаруй иргэн, 4562 татвар төлөгчийг хамруулсан байна. Татварын алба нь татвар төлөгчдөд 100 хувь цахим үйлчилгээг үзүүлэхээс гадна 15 сум, 1 тосгонд татвар төлөгчийн цагийг хэмнэх, татварын үйлчилгээг нэг дороос үзүүлэх, татвар төлөгчийн ажлын байр болон газар дээр нь татвар, төлбөр, хураамжийг хураах үйлчилгээг бүрэн хүргэх зорилгоор "ГЭРЭГЭ ПОС" төхөөрөмжийг ашиглан татварын үйлчилгээг хурдан шуурхай, хүндрэлгүй, хүргэж байна.	100
2.1.5	Төсөв, санхүүгийн цахим систем нэвтрүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, үр ашигтай болгож, төсвийн зардлын ил тод байдлыг хангана.	Цахим шилжилтийн бодлого, зорилттой уялдуулан төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхээр төрийн сангийн цахимжуулах сургалтыг аймаг, сумын төсвийн байгууллагын дарга, нягтлан бодогч 290 албан хаагчид зохион байгуулсан. Мөн 156 төсөвт байгууллагын цалингийн гүйлгээг "Төрийн албаны цалингийн нэгдсэн систем"-ээр бүрэн цахимжуулсан бөгөөд улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйлгээг цахимаар бүртгэж, баталгаажуулалтыг нэвтрүүлээд байна. Төсвийн байгууллагуудын зарлагын гүйлгээг "Портал систем"-д нэвтрүүлэх үе шаттай сургалт, дадлагажуулалтын ажлын хүрээнд 2022 оны 11 дүгээр сарын 29-30-ны өдрүүдэд төсвийн захирагч, нягтлан бодогч, санхүүгийн ажилтнуудыг хамарсан 250 хүний сургалтыг зохион байгуулсан бөгөөд 2023 оны төсвийн жилээс төсвийн бүх төрлийн зарлагын гүйлгээ Засгийн газрын цахим төлбөр тооцоонд нэвтрэхээр болж байна. Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллаж, 2022 оны жилийн эцсийн байдлаар шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 99.4 хувьтай мэдээлсэн байна.	85.0

2.1.6	<p>Аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэл хөтлөлт, олон улсын стандарт нэвтрэлтийг сайжруулах замаар төсвийн орлогын бүрдүүлэлт, төсвийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлж, удирдлагын бүх шатанд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн оновчтой шийдвэр гаргаж, хэрэгжүүлнэ.</p>	<p>Аймгийн хэмжээнд 2021 оны жилийн эцсийн байдлаар санхүүгийн тайлангийн цахим санд бүртгэлтэй 1302 аж ахуйн нэгж, байгууллага байна. 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн ирц 92.0 хувийн гүйцэтгэлтэйгээр Сангийн яаманд хуулийн хугацаанд нэгтгэгдсэн. Санхүүгийн тайланг хянаж баталгаажуулах явцад нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу алдаатай тайланг залруулах мэргэжлийн зөвлөгөөг өссөн дүнгээр 321 аж ахуйн нэгж, байгууллагын захирал, нягтлан бодогч нарт өгсөн. Шинээр үүсэн байгуулагдсан аж ахуйн нэгж, байгууллагуудад цахим санхүүгийн тайланд бүртгүүлэх, санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа өгөх тухай зөвлөмжийн хуудсыг Улсын бүртгэлийн хэлтэст байрлуулан мэдээллээр хангаж байна. Санхүүгийн тайлангаа хуулийн хугацаанд ирүүлээгүй 93 байгууллагад албан бичиг хүргүүлж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, үүнээс 7 байгууллагад Зөрчлийн тухай хуулийн дагуу тус бүр 400.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авлаа. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан "Зөрчилгүй" санал дүгнэлт авсан. Өмнөх онтой харьцуулбал аудитын акт, албан шаардлагын хэмжээ өсөж, зөвлөмжийн тоо буурсан нь сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагыг урт, богино хугацаагаар ялгаж бүртгэх, ашиглалтын хугацаа дууссан үндсэн хөрөнгийг дахин үнэлж данс бүртгэлд тусгах асуудалд албан шаардлага өгсөн нь нийт алдаа зөрчил нэмэгдэхэд нөлөөлж байна. Төсвийн байгууллагуудын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, аж ахуйн нэгж, байгууллагын тайлан нэгтгэх, 2022 оны төсвийн шинэчлэл, цахим шилжилт, төсвийн захирагч нарын жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэлд анхаарах асуудлаар санхүүгийн албаны дарга, мэргэжилтэн, нягтлан бодогч нарт 9 удаагийн цахим сургалт, уулзалтыг зохион байгуулж, зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан. 2022 оны төсвийн хэрэгжилттэй танилцах, зөвлөн туслах чиглэлээр 16 сум, 1 тосгонд ажиллалаа.</p>	80.0
<p>2.2.Хөдөө аж ахуй. Хөдөө аж ахуйг байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ, шаардлагад нийцсэн, хариуцлагатай, бүтээмж өндөр, тогтвортой үйлдвэрлэлтэй эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ.</p>			
2.2.1	<p>Хөдөө аж ахуйн салбарын материаллаг бааз, боловсон хүчний хангамжийг сайжруулна.</p>	<p>Хөдөө аж ахуйн салбарын материаллаг бааз, хүний нөөцийн хангамжийг сайжруулах зорилгоор Хөдөө Аж Ахуйн Их Сургуультай хамтран дутагдалтай байгаа орон тоог нөхөж ажиллуулах, давтан сургах, шинээр төгсөгчдийг орон нутагтаа ажиллахад уриалах ажлуудыг зохион байгуулж, хамтран ажиллах гэрээг байгуулаад байна. Энэ онд давхардсан тоогоор 350 тариаланч, 1215 малчин, Хөдөө аж ахуй, Мал эмнэлгийн тасгийн 220 гаруй албан хаагчдыг сургах, мэдлэг мэдээллээр хангах ажлыг зохион байгууллаа. Шинэ Зеланд улсын "Шэйр Монголиа" төрийн бус байгууллагын мэргэжлийн багш нар цахилгаан хайчаар хонины ноос хяргах, ноос ангилах олон улсын туршлагыг нэвтрүүлэх зорилгоор хонины ноос хяргах сургалтыг 2022 оны 06 дугаар сарын 15-19-ний өдрүүдэд Дашинчилэн суманд зохион байгууж, 15 малчин залуус хамрагдан, сертификат, 4 ширхэг иж бүрэн ноос хяргах тоног төхөөрөмж авсан. Мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн барилгын хэсэг болох вакцин хадгалах хөргүүрийг орон нутгийн төсвийн 24.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар засварлаж, тоног төхөөрөмжийг шинэчиллээ. Мөн орон нутгийн 50.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Мал эмнэлгийн газарт ариутгал, халдваргүйтгэлийн ДУК автомашин нийлүүлж, ажил үйлчилгээг шуурхай хүргэх боломжийг бүрдүүлээд байна. Орон нутгийн төсвийн 166.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Бүрэгхангай, Дашинчилэн, Могод, Хутаг-Өндөр суманд мал эмнэлгийн зөөврийн хашаа, малын тоо толгойн албан татварын орлогоор 16 сумын 50 багт 50 үзлэг ангилалтын зөөврийн хашааг засварлаж, ашиглалтад оруулснаар аймгийн хэмжээнд үзлэг ангилалтын зөөврийн хашааны хангалт 50.0 хувьд хүрлээ.</p>	83.3
2.2.2	<p>"Шинэ хөдөө-Булган" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг бүрэн хангаж, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжийг сайжруулна.</p>	<p>Бүрэгхангай, Гурванбулаг, Дашинчилэн, Сайхан суманд орон нутгийн 51.5 сая төгрөг, аж ахуйн нэгжийн 72.0 сая төгрөг, малчдын өөрийн 59.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Баяд" үүлдрийн 373 толгой хурган хуц, Дархад үүлдрийн 630 толгой хуцыг худалдан аваад байна. Ямааны ашиг шим, ноолуурын гарц, чанарыг сайжруулахаар үржлийн нэгж болон малчдын түвшинд 250 ухна ишиг өсгөн бойжуулж байна.</p>	85.0
2.2.3	<p>"Чинээлэг малчин" дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, малын чанар, ашиг шимийг сайжруулах ажлыг эрчимжүүлж, дотоодод мал, махны худалдааг нэмэгдүүлэн экспортод гаргаж, малчдын орлогыг өсгөнө.</p>	<p>"Чинээлэг малчин" хөтөлбөр хэрэгжүүлснээр хээлтэгч малын хувийн жин бод малд нийт сүргийн 39.1 хувь буюу өмнөх жилээс 2.7 пункт, бог малд 489.6 хувь буюу өмнөх жилээс 3.2 пунктээр тус тус нэмэгдсэн байна. Эр сувай мал нийт сүргийн 584.4 мянган толгой буюу 16.0 хувьд хүрч 1.2 пункт буурч, үхэр сүргийн нийт сүрэгт эзлэх хувийн жин өмнөх оноос 0.4 хувь өссөн байна. Өсвөр хээлтүүлэгчийг нөхөж тавьснаар бог малын хээлтүүлгийн тохироо нормативт хэмжээнд ойртож хуц 85, ухна 80 харьцаатай болсон. Хөтөлбөрийн хэрэгжилт 2022 оны жилийн эцсийн байдлаар 48.5 хувьтай байна. Дутагдалтай байгаа хээлтүүлэгчийг нөхөж тавих замаар малын чанар ашиг шимийг сайжруулах ажлын хүрээнд орон нутгийн 182.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баян-Агт сумын "Агтын шилмэл сүрэг" ХХК, Бүрэгхангай сумын "Алтан бичигт цахт" ХХК, Гурванбулаг сумын "Блек ангус" ХХК, Дашинчилэн сумын "Хужрын адаг" ХХК, Сэлэнгэ сумын "Ингэт сүрэг" мал үржлийн нэгжүүд болон малчдын түвшинд 950 өсвөр хээлтүүлэгчийг нөхөж тавьсан.</p>	98.5

2.2.4	Мал аж ахуй эрхлэлтийг дэмжих, өндөр ашиг шимтэй малын нийт сүрэгт эзлэх хувийг 25-д хүргэнэ.	Нийт мал сүргийн 1.2 хувь нь цэвэр эрлийз үүлдрийн, 21.3 хувь нь сайжирсан үүлдрийн, 77.4 хувь нь нутгийн монгол мал байна. Гурванбулаг сумын "Блек ангус" ХХК өнгөрсөн жил Лимузин, Хар ангус үүлдрийн үхрийн 37 тугал бойжуулан, 30 үнээнд зохиомол хээлтүүлэг хийсэн байна. Махны үхрийн 1 аж ахуйн нэгж, 5 иргэний 515 толгой үхэр, сүү-махны үхрийн 1 аж ахуйн нэгж, 12 иргэний 455 толгой үхэр, сүүний үхрийн 1 аж ахуйн нэгжийн 57 үхэр, нарийн, нарийвтар ноост хонины 1 аж ахуйн нэгжийн 200 толгой хонийг цэврээр нь үржүүлж байгаа нь өндөр ашиг шимтэй малын нийт сүрэгт эзлэх хувь хэмжээг 22.5-д хүргэж байна. Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас гахайн аж ахуйг хөгжүүлэх чиглэлээр Булган сумын "Энхжин хүнс" ХХК 100.0 сая төгрөг, Орхон сумын "Булган Милк" ХХК хоршоо хөгжүүлэх сангаас 70.0 сая төгрөг авч сүүний үхэр, Тэшиг сумын "Тэшиг агро" ХХК махны чиглэлийн 275 үхэр, Сэлэнгэ суманд 1 иргэн сүүний чиглэлийн "Алатау" үүлдрийн үхэр, Булган сумын 1 иргэн сүүний чиглэлийн үхрийн аж ахуй байгуулахаар зээлд хамрагдсан байна. Бугат сумын жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн зээлд сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах чиглэлээр "Цуулбар өргөө" ХХК, мах сүүний хосолмол ашиг шимт "Монбелярд" үүлдрийн үхрийн "Бугат агро" ХХК тус тус хамрагдсан бөгөөд мэргэжлийн байгууллагууд эдгээр компаниудын үйл ажиллагаатай танилцаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Дээрх ажлуудын дүнд эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийн тоо өмнөх оноос 4-өөр нэмэгдэж, 14 болсон. Хишиг-Өндөр сумын "Дархан хаан Молор" ХХК малын тэжээлийн үйлдвэр байгуулж, 98 га талбайд тариалалт хийж, 48 тн тэжээл хураан авлаа.	100
2.2.5	Хадлан, бэлчээрийн талбайг зохистой ашиглах, нөхөн сэргээх, уст цэгийн хайгуул судалгаа хийж, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлнэ.	Баяннуур сумын Бор булангийн хадлангийн талбайг засварлах ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах тендер Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд зарлагдсан. Энэ онд Хишиг-Өндөр сум 90 га, Рашаант сум 626 га, Сайхан сум 100 га талбай, Сэлэнгэ сум 2 иргэнд хадлангийн зориулалтаар талбай олгов. "Шинэ хөдөө" төслийн 300.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хадлангийн зориулалттай 90 морины хүчин чадал бүхий дундын техник, 50 морины хүчин чадал бүхий иж бүрэн дундын техник нийлүүлэхээр болсон. Аймгийн хэмжээнд жил бүр 715.0 мянган мал зах зээлд борлуулдаг бөгөөд бод мал 78.8 мянган толгой, бог мал 636.2 мянган толгой байна. Дотоодын хэрэгцээнд 474.0 мянган толгой мал хэрэглэж байна. Энэ онд 1.2 сая толгой мал эдийн засгийн эргэлтэд оруулсан. Үр үржүүлэх сургалтыг Дашинчилэн суманд зохион байгуулж, Баяннуур, Гурванбулаг, Рашаант, Хишиг-Өндөр сумын 33 малчин хамрагдлаа. Эдгээр малчдад 1075 кг үр олгож тариалалт хийлгэлээ. Монгол, Хятадын Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж байгаа "Доройтсон бэлчээрийг зайнаас тандах аргаар судалж, сайжруулах туршилт судалгааны төсөл"-ийн баг Гурванбулаг сумын 10 га газарт бэлчээрийг нөхөн сэргээх, бэлчээрийн 8 сорт таримлыг нутагшуулах замаар иргэдэд үзүүлэх сургалтыг зохион байгуулсан.2022 онд улсын төсвийн 178.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Бугат, Гурванбулаг, Дашинчилэн, Могод суманд тус бүр 1 худаг шинээр гаргах тендерийн дагуу "Булган-Ус" ХХК 4 худаг гаргаж хүлээлгэн өгсөн. Мөн орон нутгийн төсвийн 185.0 сая төгрөгийн хөрөнгөөр Булган, Бүрэгхангай, Дашинчилэн, Могод, Орхон, Сайхан, Тэшиг, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр суманд шинээр 10 худаг, Бугат, Орхон, Тэшиг, Хутаг-Өндөр суманд 140.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 12 худаг, малчид 24.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2 худаг, нийт 28 худаг шинээр гаргаж, 36.0 мянган га талбайд бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлээ.	74.0

2.2.6	Малын гоц халдварт, халдварт өвчний эрсдэл бүхий бүс нутагт мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнг сайжруулна.	Орон нутгийн төсвийн 66.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар энэ онд 55 мал эмнэлэг, үржлийн нэгжтэй гэрээ байгуулан шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 4.0 сая мал амьтан хамруулахаар төлөвлөснөөс 3.1 сая толгой мал амьтан хамруулаад байна. "Монгол мал" хөтөлбөрийн хүрээнд улсын төсвийн 296.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар бруцеллээс өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээнд 724.0 мянган толгой мал хамруулахаас 690.4 мянган толгой мал хамруулж, гүйцэтгэл 95.4 хувьтай байна. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд орон нутгийн төсвийн 607.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 1488.1 мянган толгой мал, амьтан хамруулахаас 1398.8 мянган толгой мал, амьтан хамруулж, 94.0 хувийн гүйцэтгэлтэй ажилласан. Аймгийн хэмжээнд мал, амьтны шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтад 9211 өрхийн 362.0 мянган толгой мал, амьтан хамруулахаас 4181 өрхийн 343.9 мянган толгой мал, амьтан хамруулж, 95.1 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлээд байна. Жил бүр тандалт шинжилгээнд холбогдох гэрээ дүгнэсэн акт, санхүүгийн зарцуулалтын тайлан тооцоо, эерэг гарсан дээжийг тухайн өвчинтэй тэмцэх зааврын дагуу хэрэгжүүлж байна. Архаг халдварт өвчинтэй тэмцэх, хяналт тандалтын ажлыг сайжруулах хүрээнд энэ онд 19.9 мянган мал хамруулахаар төлөвлөж, 18.5 мянган толгой мал хамруулж, 92.9 хувийн гүйцэтгэлтэй байна. Бруцеллээс өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 773.4 мянган төл мал хамруулахаас 744.7 мянган толгой мал, амьтан хамруулж, өвчний гаралт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.6 хувиар буураад байна. Сүрьеэ, лейкоз өвчнөөс эрүүл сум, аж ахуйн нэгжийг баталгаажуулахаар судалгааны ажлыг хийж байна.	63.3
2.2.7	Мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүнд антибиотек, пестицидийн үлдэгдэл тодорхойлж, малын эмийн зохистой хэрэглээг хангана.	"Малын эмийн үлдэгдлийг хянах" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн 2021-2023 оны ажлын төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Лабораторийн шинжилгээний итгэмжлэлийн хүрээг өргөтгөх зорилгоор малын мах, сүү, өндөг, малын тэжээлд MNS 6665-2017 стандартын дагуу эмийн үлдэгдлийн шинжилгээг хийх эрхийг Үндэсний итгэмжлэлийн төвийн 2021 оны А/124 дүгээр тушаалаар баталгаажуулсан. Мах, сүүнд эмийн үлдэгдэл илрүүлэх багаж, оношлуурын нөөц бүрдүүлж, сургууль, цэцэрлэг, нийтийн хоолны үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгжийн махны 81 дээж, сүүний 3 дээжид антибиотекийн үлдэгдэл илрүүлэх шинжилгээ хийж, 2023 онд оношлуурын багаж төхөөрөмжийн хангалтад шаардагдах 45.0 сая төгрөгийн хөрөнгийг шийдвэрлүүлэхээр Мал эмнэлгийн ерөнхий газарт, "Шинэ хөдөө" төсөлд тус тус санал хүргүүлсэн.	50.0
2.2.8	Атрын IV аяныг орон нутагт хэрэгжүүлж, хөрсний үржил шимийг хамгаалах, нөхөн сэргээх, үр сортын болон техник, технологийн шинэчлэлийг эрчимжүүлнэ.	Энэ онд Дашинчилэн сумын "Өрхтий трейд" ХХК, "Мүкү" ХХК 2670 га талбай, Хишиг-Өндөр сумын "Дархан хаан молор" ХХК 197 га, Хужиртын ногооны газар 6.2 га, Жимс жимсгэний плантаз 6.7 га, Баяннуур сумын иргэн Б.Түвшинжаргал 100 га талбай, Сэлэнгэ сумын 16 аж ахуйн нэгжийн 4090.3 га талбай, Бугат сумын 3 аж ахуйн нэгжийн 2050 га талбай, Бүрэгхангай сумын 2 аж ахуйн нэгжийн 340 га талбай, нийт 9460.2 га талбайг "Ургамал газар тариалангийн хүрээлэн"-ийн агрохимийн шинжилгээнд хамруулсан. Хутаг-Өндөр сумын "Улаанбуудайн эх газар" ХХК, Сэлэнгэ сумын "ИНТОСЭ" ХХК, "Оргилдэлгэрэх" ХХК, Хангал сумын "Молор-Эрдэнэ түрүү" ХХК, Орхон сумын "Орхон бодь" ХХК-иуд Дархан-Уул аймгийн Эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран нутагшсан сортын үр үржүүлэхээр туршилтын тариалалт хийж, нэгжээс 11-28 цн ургац хураан авсан. Энэ онд тариалан бүхий 5.8 км газар хамгаалалтын ойн зурвас байгууллаа. Үүнд: Баян-Агт сум 1 га талбайд 84 ширхэг мод, Бугат суманд 56 га талбайд 5731 ширхэг, Булган сумын "Маргад-Орхон" ХХК нь 130 метр газарт тариалангийн талбайн ойн зурвас байгуулсан. Рашаант сум төмс хүнсний ногооны талбайд 200 ширхэг суулгац, чацарганы 10 га талбайг тойруулан 2 үе хамгаалалтын зурвас байгуулсан бөгөөд цаашид 10 га чацарганы талбайд хамгаалалтын зурвас байгуулахаар төлөвлөсөн. Дашинчилэн сумын "Өрхтий трейд", "Мүкү" ХХК-иуд 8000 ширхэг модыг 2023 онд тарихаар төлөвлөөд байна.	63.3
2.2.9	Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг механикжуулж, аймгийн хүн амын хүнсний ногооны хэрэгцээг 50-иас доошгүй хувиар хангана.	Зэд Хантай Бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанд хэрэгжиж буй "Биологийн олон янз байдлыг хамгаалах уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох" төслөөс орчны бүсийн сумдын иргэдийн өрхийн амьжиргааг дэмжих зорилго бүхий "Хүнсний ногооны нэмүү өртгийг дэмжих нь" дэд төсөлд Сэлэнгэ сумын 17 өрхийн 64 иргэн хамрагдаж, трактор дагалдах агергатууд, Бугат сумын "Найрамдал Бугат" хоршоонд "Шинэ хөдөө-Булган" хөтөлбөрийн хүрээнд 40 морины хүчин чадалтай төмс, хүнсний ногоо тариалах иж бүрэн төхөөрөмж тус тус олгосон. 2022 онд 540 га-д төмс, 220 га-д хүнсний ногоо тариалахаар төлөвлөснөөс төмс 469 га-д тариалж, 3362.7 тн, хүнсний ногоо 293.4 га-д тариалж, 2019.2 тн-ыг тус тус хураасан нь өмнөх оноос 151.5 тонноор нэмэгдэж, хүн амын хүнсний ногооны 38.0 хувийг хангаж байна. Бүрэгхангай сум тариаланчдыг бүлгийн зохион байгуулалтад оруулах зорилгоор 1 га газрыг төлөвлөн, гүний худаг гарган ажиллаж байна. Хишиг-Өндөр сумын "Эко сум" ТББ-тай хамтарсан Европын холбооны санхүүжилтээр хэрэгжиж байгаа төслөөс бага, дунд оврын төмс үрлэгч, копатель, роторт сийрүүлэгч, нарийн ногоо үрлэгч, мотоблокийн хамт нийлүүлээ.	100

2.2.10	Хамгаалагдсан хөрсний үйлдвэрлэлийг өмнөх оноос 2 дахин нэмэгдүүлж, хүнсний ногоо, нарийн ногооны нэр төрлийг олшруулж, сумуудад өвлийн болон нарлаг хүлэмж, агуулахын аж ахуйг хөгжүүлнэ.	"Шинэ хөдөө" төслөөс 60.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 25 хүлэмж, "Монгол ногоо" төслийн 9.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Жишиг гудамж" төслийн загвараар 5 хүлэмж, Сэлэнгэ суманд 3.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2 хүлэмж нийлүүлэгдсэнээр хамгаалагдсан хөрсний үйлдвэрлэл өмнөх оноос 1240 м.кв-аар нэмэгдэж, хүнсний ногоо, нарийн ногооны нэр төрлийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүллээ. Булган суманд 1000 м.кв бүхий өвлийн хүлэмж байгуулах зураг төсвийг боловсруулсан бөгөөд хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй байна.	25.0
2.2.11	Сум дундын 500 тоннын багтаамжтай механикжсан зоорь барьж, ашиглалтад оруулна.	Бүгд Найрамдах Польш Улсын санхүүжилтээр хэрэгжиж буй "Хүнсний ногооны үйлдвэрлэлд нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх" төсөлд хамрагдахаар Булган суманд 1000 тоннын багтаамжтай механикжсан зоорь барих зураг төсөв, газрын асуудлыг шийдвэрлэж, холбогдох материалыг Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлээд байна.	30.0
2.2.12	Малын тэжээлийн ургамал тариалж, үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх замаар мал аж ахуйн үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлнэ.	Аймгийн хэмжээнд энэ онд 3324 га-д ногоон тэжээл тариалж, 12250 тонныг хураасан. Үүнээс шинээр 108 га-д 49 иргэн ногоон тэжээл тариалсан. Баяннуур сум Молцогт ногоон тэжээлийн зориулалтаар 100 га талбайг 20 иргэнд бүлгийн зохион байгуулалттайгаар гэрээгээр олгон тариалалт хийж, "Шинэ хөдөө" төслөөс 1 бүл хадлангийн зориулалттай иж бүрэн трактор 5 жилийн гэрээгээр авсан. Бугат суманд 2 хоршоо, 44 өрхөд 275 га талбайг тэжээлийн ургамал тариалах зориулалтаар гэрээ хийж олгон, тариалалт хийсэн. Мөн Орхон сум атаршсан 238.2 га, Дашинчилэн сум 167.5 га газрыг тэжээлийн ургамлын усалгаагүй тариалан эрхлэх зориулалтаар олгож, тариалалт хийсэн. Энэ онд вандуй 210 кг, овьёос 360 кг, арвайн шимт 120 кг, бурхант-1 100 кг, тритикал анар 135 кг, хөх тариа 150 кг, нийт 1075 кг ногоон тэжээлийн үрийг малчдын бүлэг, хоршоодод тараалаа. Бүрэгхангай суманд хэрэгжүүлсэн "Ногоон тэжээл" төслийн бүлгүүд 120 морины хүчин чадалтай 3 трактор, 35 морины хүчин чадалтай 3 трактор, 3 хаман боогч, 3 саран хадуур, Рашаант сумын малчид, иргэд өөрсдийн хөрөнгөөр ногоон тэжээл тариалах зориулалтаар 3 ширхэг трактор /хуучин/, 4 ширхэг хаман боогч, 3 ширхэг тармуур тус тус авсан. Дашинчилэн сумын иргэнд "Шинэ хөдөө" төслөөс 53.6 сая төгрөгийн өртөгтэй тракторыг зээлээр олгосон байна.	75.0
2.3. Үйлдвэрлэл, үйлчилгээ. Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэх таатай орчныг бүрдүүлж, бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлж, экспортын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлж, ажлын байр бий болгоно.			
2.3.1	Жижиг, дунд, үйлдвэрлэлийн зөвлөх үйлчилгээг хөгжүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэл хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	Орон нутгийн онцлог нэрийн бүтээгдэхүүнийг "Органик бус хүнснээс органик хүнс рүү шилжүүлэх" зорилгоор "Гурванборхууд" ХХК-ийн "Арвайн гурил", "Тунамал Өгөөж" ХХК-ийн цайны цуврал, "Сүргийн нуга" ХХК-ийн "Зөгийн бал" зэрэг 5 нэрийн бүтээгдэхүүнийг органик бүтээгдэхүүний шаардлагад нийцүүлэх төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн 9 аж ахуйн нэгжийн 22 бүтээгдэхүүн тохирлын үнэлгээний шаардлагад нийцэж, баталгаажсан. Хангинахын шугуйн шагайн тойром, Айраг наадам, Айраг DAY, ITM эвент арга хэмжээнүүдэд орон нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид болон 325 аж ахуйн нэгж, иргэдийг оролцуулан 1.0 тэрбум гаруй төгрөгийн бүтээгдэхүүний борлуулалт хийж, сурталчилж ажилласан. "Аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, орон нутгийн онцлогтой брэнд хоол шалгаруулах, хоол үйлдвэрлэлийн уламжлал ба инноваци-2022" сургалт, арга хэмжээнд 11 сумын 8 багийн 146 хоол үйлдвэрлэлийн салбарын ажилчид оролцож, ур чадвараа сорьлоо. "Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлж, иргэдийн тогтвортой чанартай үйлчилгээ авах нөхцөл бүрдүүлэх" зорилтыг хэрэгжүүлэхэд 2022 онд улсын болон орон нутгийн төсөв, "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газраас 995.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, салбарын 90 жилийн ойг угтаж, ойн арга хэмжээг мэргэжлийн холбоотой хамтран тэмдэглэн өнгөрүүллээ. "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын 299.9 сая төгрөгийн санхүүжилтээр Оёдлын үйлдвэрийн байр, Шинэ хөдөө төслийн 76.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар үйлдвэрийн тоног төхөөрөмжийг худалдан авч суурилуулж, үйлдвэрийн нээлтийг хийв. Бизнес хөгжлийн төв буюу ахуйн үйлчилгээний төв барих 654 м.кв газрыг шийдвэрлэж, ажлын даалгаврыг боловсруулсан.	90.0

2.3.2	Жижиг, дунд үйлдвэрлэлд санхүүжилтийн олон эх үүсвэрээс дэмжлэг үзүүлнэ.	Хоршоо хөгжүүлэх сангаас 1.8 тэрбум гаруй төгрөгийн эх үүсвэрээс зээл олголт хийгдэж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад чанаргүй зээл 10.0 хувиар буурсан. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих дэд сангаас 2 аж ахуйн нэгж 160.0 сая төгрөг, хөдөө аж ахуйг дэмжих сангаас үр тарианы 26 аж ахуйн нэгж, иргэнд 2264.3 сая төгрөг, хүнсний ногоо тариалагч 37 аж ахуйн нэгж, иргэн 733.8 сая төгрөгийн зээлийн дэмжлэгт хамрагдсан. "Ажлын байрыг дэмжих" 3.0 хувийн хүүтэй зээлийн төслүүд амжилттай хэрэгжиж байна. ЖАЙКА /JICA/-ын санхүүжилттэй "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, байгаль орчныг хамгаалах-II" төслийн 6.0 хувийн хүүтэй 10 жилийн хугацаатай зээлийн мэдээллийг аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газрын цахим хуудас, "Сайхан Монгол" ТВ болон сумын мэргэжилтнүүдээр дамжуулан аж ахуйн нэгжүүдэд сурталчилж байна. Зээлийн батлан даалтын сангийн мэдээллийг "Хүнсний хувьсгал" нээлтийн арга хэмжээний үеэр 100 гаруй иргэн болон 16 суманд цахимаар өгөв. Хөдөө аж ахуйг дэмжих сангаас үр тарианы 26 аж ахуйн нэгж, иргэнд 2264.3 сая төгрөгийн, хүнсний ногоо тариалагч 37 аж ахуйн нэгж, иргэнд 733.8 сая төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлсэн.	95.0
2.3.3	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, уул уурхайн болон аж ахуйн томоохон байгууллагуудын захиалгат ажлыг орон нутгийн жижиг, дунд бизнес эрхлэгчдээр гүйцэтгүүлж, орлого нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.	Уул уурхай дагасан жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, аймгийн Засаг даргын хамтын ажиллагааны гэрээнд тусгагдсаны дагуу үйлдвэрийн 300.0 сая төгрөгийн санхүүжилтээр оёдлын үйлдвэрийн байртай болж, үйлдвэрийн ажилчдын хөдөлмөр хамгааллын хувцас үйлдвэрлэх, орон нутгийн иргэдийг ажлын байртай болоход дэмжлэг үзүүлсэн. Аймгийн Засаг дарга, "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газар, Бүрэгхангай сумын уурхайнуудтай байгуулсан хамтран ажиллах гэрээнд Булган аймагт үйлдвэрлэсэн чанарын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрийн хэрэгцээнд нийлүүлэхээр тусгаж, орон нутгийн үйлдвэрийн бүтээгдэхүүнийг стандартын шаардлагад нийцүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлж байна. Уул уурхай эрхлэгчидтэй зөвлөлдөх уулзалт зохион байгуулж, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн болох мах, сүү, цагаан идээ, хүнсний ногоо зэргийг орон нутгаас нийлүүлэх талаар 14 аж ахуйн нэгжтэй зөвшилцөлд хүрч, 3 аж ахуйн нэгж 640.0 сая төгрөгийн бүтээгдэхүүний худалдан авалт хийсэн. Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоолын төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, төр хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах, түншлэлд оролцогч байх заалтын хүрээнд "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газарт бүтээгдэхүүн нийлүүлэх бололцоо бүхий аймгийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн судалгааг хүргүүлсэн. "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын ажилчдыг гэрээгээр амраадаг амралт, аялал жуулчлалын 11 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд Тохирлын үнэлгээ хийж, гэрчилгээ олгосноор орон нутгийн аж ахуйн нэгжүүд тус үйлдвэртэй гэрээгээ үргэлжлүүлэн ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн.	100
2.3.4	Булган суманд стандартын шаардлагад нийцсэн өндөр зэрэглэлийн зочид буудал шинээр барьж ашиглалтад оруулна.	Аймгийн Засаг даргын 2021 оны А/162 дугаар захирамжаар "Супрема бүтик лоджес" ХХК-нд 10814 м.кв газрыг зочид буудлын зориулалтаар газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнэ 64.8 сая төгрөгийг төлүүлэн газар эзэмших гэрээ, гэрчилгээг олгосон. Зочид буудлын барилгын ажил 68.0 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.	70.0

2.3.5	Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулна.	Шинээр үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний 28 цэг ашиглалтад орж, 60 гаруй байнгын ажлын байрыг бий болгосон. Бүгд Найрамдах Чех Улстай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний дагуу барилгын дулаалгын материалын үйлдвэр байгуулахаар үйлдвэрийн үндсэн түүхий эдийг тус улсын лабораторид технологийн туршилт хийлгэхээр явуулж, үйлдвэр барих газрыг шийдвэрлэв. БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн дэмжлэгээр "Махны үйлдвэр, хорио цээрийн бүс бүхий цогцолбор" барих газрыг шийдвэрлэсэн. Оёдлын үйлдвэр байгуулагдаж, "Бизнес инкубатор" төв барих газар, зураг төсвийн үнийг шийдвэрлэсэн. Тэшиг суманд баригдах "Сүү, цөцгийн тосны үйлдвэр"-т 2022 оны улсын төсвөөс 300.0 сая төгрөг хуваарилж, ТЭЗҮ-г боловсруулан барилгын ажлын шавыг тавьсан. "Эдийн засгийн өсөлт болон бизнес эрхлэлтийг дэмжих төсөл"-ийн чадавхжуулах сургалтад 180 гаруй иргэн, аж ахуйн нэгж, үсчин, гоо засал, тогооч, хоршоологч 40 орчим хүнийг 4 удаагийн туршлага судлуулах арга хэмжээнд хамруулсан. "Хүнсний хангамж, аюулгүй байдал-хүнс үйлдвэрлэл" үндэсний арга хэмжээний нээлтийг зохион байгуулав. Орон нутгийн бүтээгдэхүүнийг сурталчлах, орлогыг нэмэгдүүлэх үзэсгэлэн худалдаанд Улаанбаатар хотод 2 удаа, орон нутгийн нэгдсэн 3 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор 400 орчим малчид, тариаланч, үйлдвэрлэгчдийг хамруулж, 1.4 тэрбум орчим төгрөгийн борлуулалт хийсэн байна. Стандарт хэмжил зүйн хэлтэс улсын төсвийн 50.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар технологийн автомашин болон 20.0 сая төгрөгийн өртөг бүхий 5 төрлийн эталон төхөөрөмж, зөөврийн болон суурин компьютероор хангагдаад байна. "Хутаг-Өндөр мах маркет" ХХК нь улсын нөөцөд 250 тн мах, аж ахуйн нэгжийн захиалгаар 250 тн мах бэлтгэн нийлүүлж, 500 тн хонины мах экспортлох зөвшөөрөл авч 270 тн мах экспортлоод байна. Хангал суманд "Хялганат эко мах" ХХК нь хоногт 50 бод, 200 бог мал нядлах хүчин чадалтай, 50 тоннын багтаамжтай хөргүүртэй агуулах бүхий үйлдвэр ашиглалтад оруулсан нь үйлдвэрийн аргаар бэлтгэгдсэн махны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлж байна. Булган сумын "Хатан мээж хайрхан" ХХК малчдаас 450 тн сүү авч, 315.0 сая төгрөгийн орлого олох боломжийг бүрдүүлсэн. Хатан Мээж хайрхан ХХК гэрээт аж ахуйн нэгжүүдэд цөцгийн тос, аарцыг нийлүүлж, бэлтгэн нийлүүлэгчээс түүхий сүү хүлээн авах, сүүний урамшуулалд хамрагдах эрх авч 10 тн шингэн сүү өвлийн улиралд авах, гэрээ хийгдсэн. Булган сумын "Эко хүнс" ХХК-ийн "Чихэртэй ааруул", "Чихэргүй ааруул" нэрийн бүтээгдэхүүн тохирлын үнэлгээгээр баталгаажсан. Махны үнийг тогтворжуулах зорилгоор аймгийн төвийн хүн амд зах зээлээс 2000-2500 төгрөгийн хямд үнэтэй 10.2 тн махыг гэрээний дагуу бэлтгэн нийлүүлэх ажлыг зохион байгуулав.	84.0
ГУРАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО			
3.1. Байгаль орчин. Байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, хамгаалах, орчны бохирдол, доройтлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлж, эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлнэ.			
3.1.1	Ус, рашааны судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулж, усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, хэмнэх, хуримтлуулах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Усан сан бүхий газрын хамгаалалтын бүсэд 200 ширхэг мэдээллийн самбар, тэмдэгжүүлэлтийн ажлыг Хануй болон Сэлэнгэ голын сав газрын захиргаанууд хийсэн. Аймгийн хэмжээнд 2022 онд усны тоо бүртгэлийн судалгаагаар 418 гол горхи, 152 нуур тойром, 805 булаг шанд, 9 хөв цөөрөм, 1581 худаг тоологдсон байна. Гурванбулаг, Рашаант суманд хөв цөөрөм байгуулах ажлын зураг төсвийг боловсрууллаа.	76.7
3.1.2	Аймгийн ойн сангийн ашиглалтад хамгаалалтын зохистой менежментийг хэрэгжүүлнэ.	Мод бэлтгэлийн аж ахуйн нэгжүүд 47.4 га талбайд, байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний хүрээнд 55 га ойжуулалтын ажлыг хийсэн. Аймгийн хэмжээнд 152.4 га талбайд ойжуулалт, 50 га талбайд байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг хийж гүйцэтгэлээ. Ойн хортны судалгааны ажлыг аймгийн Засаг даргын 2022 оны А/474 дүгээр захирамжаар 21.0 сая төгрөгөөр "Мөнх ногоон ой" ХХК-тай гэрээ байгуулан 311000 га талбайд гүйцэтгүүлж, 2023 онд тэмцэл явуулах талбайн судалгааг гаргав. Ойн хортны тэмцлийн ажлын тендерт "Гранд форест" ХХК, "Ойн таксац" ХХК-уд шалгарч аймгийн Засаг даргын 2022 оны А/368 дугаар захирамжаар гэрээ байгуулан 7 сумын 12000 га талбайд 382.9 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн. Хожуул төслийн хүрээнд Баян-Агт, Бугат, Бүрэгхангай, Орхон суманд 3760.4 м.куб модыг сум орон нутгийн иргэдийн хэрэгцээнд нийлүүлсэн байна.	100
3.1.3	Биологийн төрөл зүйлийг хамгаалах, өсгөн үржүүлэх санаачилгыг дэмжиж, хамтран хэрэгжүүлнэ.	Орхон сумын 3 дугаар багийн Өрмийн адагт орон нутгийн төсвийн 14.0 сая төгрөгөөр 50 толгой тарвага сэргээн нутагшуулсан. Мөн нэн ховор, ховор амьтдын тархац нутагт 10 тонн өвс, 10 тонн давс, хужир, 5 тонн тэжээлийн будааг 63 цэг мараанд тавьж, Молцог хандгай, халиун буга, бор гөрөөс зэрэг нэн ховор, ховор амьтдын идэш тэжээлийн нөөцийг бий болгож, өсөж үржих боломжийг бүрдүүлэв.	100

3.1.4	Газар нутгийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах ажлыг судалгаанд үндэслэн зохион байгуулж, сүлжээг өргөтгөнө.	Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас судалгаа, шинжилгээний зөвлөх үйлчилгээний ажлыг "Байгаль хамгааллын судалгаа, хөгжлийн төв" төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, аймгийн Сэлэнгэ, Хангал сумыг дамнан орших Бүрэнгийн нуруу орчмын 48315.5 га газар нутгийг Дархан цаазат газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авах тухай саналыг боловсруулсан. Мөн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны IX/05 дугаар тогтоолоор Тэшиг сумын Дулаан хан уул орчмын 15516.5 га газрыг байгалийн цогцолборт газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авах тухай саналыг хэлэлцүүлж, Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд уламжиллаа. Баян-Агт сумын ИТХ-ын 10 дугаар хуралдаанаар "Шарга нуур" 3669 га газрыг 10/05 дугаар тогтоолоор, "Дулаан хан уул" 17049 га газрыг 10/06 дугаар тогтоолоор, "Бага нуур" 47.73 га газрыг 10/07 дугаар тогтоолоор, "Цагаан гол" рашаан хайлааст тохой 415.85 га газрыг 10/08 дугаар тогтоолоор, "Цэгээн бөөргийн нуур" 1350.3 га газрыг 10/09 дүгээр тогтоолоор, "Хануй" рашааны дэнж хүрэн толгой орчим 454.60 га газрыг 10/10 дугаар тогтоолоор тус тус орон нутгийн тусгай хамгаалалтад авч Ашигт малтмал, газрын тосны газарт хүргүүлэв.	100
3.1.5	Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгож, орчны бохирдол доройтлыг бууруулж, шинэ дэвшилтэт арга технологийг нэвтрүүлнэ.	"Цэвэр орчин-Цэмцгэр Булган" аяныг аймгийн хэмжээнд 02 дугаар сарын 10-аас 12 дугаар сарын 10-ны өдрийг дуустал зохион байгуулж, давхардсан тоогоор 701494 га газрын 8598.2 тн, 2 нуур, 137 гол горхи, уст цэгийн 778.7 тн хог хаягдлыг цэвэрлэн хогийн төвлөрсөн цэгт хүргэж, үхсэн бод малын 1188, бог малын 2978 сэг зэм, 1814 нохой, 107 муур устган халдваргүйжүүлж, энэ ажилд 481 аж ахуйн нэгж, байгууллага, иргэд болон төрийн албан хаагч 7774 хүн, 332 автомашин техник оролцож, 1334.4 сая төгрөг, 13897 л шатахуун зарцуулсан. 2022 онд орон нутгийн төсвийн 650.0 сая төгрөгөөр Баян-Агт, Бугат, Булган, Гурванбулаг, Дашинчилэн, Могод, Тэшиг, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сум, Хялганат тосгонд хог ачих зориулалтын автомашин нийлүүлэх ажлын гүйцэтгэгчээр "Цаст Хан Хөхий" ХХК шалгаран гэрээ байгуулав. 2021 онд улсын төсвийн хөрөнгөөр Аюултай хог хаягдлын түр хадгалах агуулахын барилга барих нээлттэй тендерийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас зарлаж, гүйцэтгэгчээр Улаанбаатар хотын "Жам" ХХК шалгарч, ажлын гүйцэтгэл 70.0 хувьтай байна. Булган сумын төвийн хөрсний бохирдлын хүнд металлын шинжилгээг 11 үзүүлэлтээр, агрохимийн шинжилгээг 10 үзүүлэлтээр хөрсний чанарын MNS 3310:91, MNS 5850:2008 стандартуудтай харьцуулан хийлээ. Шинжилгээний үр дүнгээр хүнд металлын агууламж ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн дотуур байрны орчимд хар тугалгын агууламж 1.7 дахин, цайрын агууламж 4 дахин, стронцигийн агууламж 1.2-1.6 дахин их үзүүлэлттэй, харин агрохимийн үзүүлэлтүүд хүлцэх агууламжаас давсан тохиолдолгүй гарсан.	92.5
3.1.6	"Нүхэн ОО -оо өөрчилье" аяныг жил бүр зохион байгуулж, гэр хорооллын айл өрх, албан байгууллагыг байгальд ээлтэй боловсон 00-той болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны санхүүжилтээр Булган сумын гэр хорооллын айл өрхийн нүхэн жорлонд хийгдэх ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлын нээлттэй тендерт Орхон аймгийн "Цэцэн шунхлай" ХХК гүйцэтгэгчээр шалгаран Булган сумын айл өрх, албан байгууллага, нийтийн эзэмшлийн газрын 2715 нүхэн жорлонд ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэлээ. Булган сумын Цоожид, Эмийн цэцэглэн өрхийн эрүүл мэндийн төв, Жаргалант зуслан, Цэцэгжин зах, Цэнгэлдэх орчим, Барилгын 36 айлын хэсэг болох нийтийн эзэмшлийн 9 байршилд 18 соруулдаг жорлон барих ажлыг 72.8 сая төгрөгөөр "Булган Мээж" ХХК гүйцэтгэж, хүлээлгэн өгсөн.	85.0
3.1.7	Ус, цаг уурын ажиглалтын болон орчны хяналт-шинжилгээний сүлжээний хэвийн ажиллагааг хангаж, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлж, байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулна.	Цаг агаарын аюултай үзэгдлээс урьдчилан сэрэмжлүүлэх чадамжийг сайжруулах үүднээс цаг уурын автомат станцуудын хэвийн ажиллагааг ханган ажиллаж, урьдчилсан мэдээний чанар 90.4, онч 100, илрүүлэлт 100 хувьтай байна. Цаг агаарын мэдээ мэдээллээр үйлчлэх ажлыг өргөжүүлж, вэб сайт (www.bulgan.tsag-agaar.gov.mn), Цаг агаар аппликэйшн, "Булган аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв" пэйж хуудсанд хагас хоног болон 1-5 хоногийн урьдчилсан мэдээ тус бүр 365, 7 хоногийн урьдчилсан мэдээ 52, сарын урьдчилсан төлөв 12, улирлын урьдчилсан төлөв 9, өнгөрсөн хоногийн тойм 365, 7 хоногийн тойм 52 удаа гаргаж үйлчилсэн. Мөн хавар, намрын улиралд түймрийн эрсдэлийн зэргийг 186 удаа бодож холбогдох газарт уламжилсан бөгөөд цаг агаарын мэдээллийг сардаа 30 мянган хэрэглэгч ашиглаж байна. Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх анхааруулга мэдээ 14, сэрэмжлүүлэг мэдээг 7, урьдчилан сэргийлэх мэдээ 1 удаа гаргаж, цаг тухайд нь багц мессежээр давхардсан тоогоор 66 байгууллага, 213140 иргэнд өгч үйлчиллээ. Байгаль орчны шинжилгээний лабораторийг итгэмжлэлд хамруулах бэлтгэл ажил бүрэн хийгдэж, итгэмжлэлийн газарт MNS ISO/IEC 17025:2018 стандартын дагуу итгэмжлэлд хамрагдах хүсэлтээ 2022 оны 7 дугаар сард хүргүүлж, газар дээрх үнэлгээний ажил 11 дүгээр сарын 14-17-ны өдрүүдэд хийгдэв. Үүлэнд зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа явуулахаар Баян-Агт, Хутаг-Өндөр сумын чиглэлд 5 дугаар сарын 27-ны өдрийн цаг агаарын процесст дүн шинжилгээ хийж, 2 экспедиц гарсан. Ихэнх нутгаар түймрийн эрсдэлийн III-IV зэргийн түвшнийг I болгон буулгаж, цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг амжилттай зохион байгууллаа.	100

3.2. Аялал жуулчлал. Байгаль, түүх, соёлын өвийн онцлог бүхий, байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн, төрөлжсөн, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засгийн үр өгөөжтэй салбар болгон хөгжүүлнэ.			
3.2.1	Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, стандартыг сайжруулан баталгаажуулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлж, жуулчдын тоог нэмэгдүүлнэ.	Аймгийн хэмжээнд 5 эвент арга хэмжээг төлөвлөн "Хангинахын шугуйн шагайн тойром"-ын арга хэмжээг 5 дугаар сарын 21, 22-ны өдрүүдэд Орхон аймагтай хамтарч, 7 дугаар сарын 06-09-ний өдрүүдэд "RFC MONGOLIA BULGANKHANGAI 2022" олон улсын бартаат замын уралдаан, 8 дугаар сарын 13-14-ний өдрүүдэд "АЙРАГ НААДАМ" арга хэмжээ, 10 дугаар сарын 8-9-ний өдрүүдэд "Airagday" арга хэмжээ, 10 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд "ITM Mongolia 2022" арга хэмжээг зохион байгууллаа. Эдгээр эвент арга хэмжээг зохион байгуулахад 224.0 сая төгрөгийг зарцуулан ажиллаж, гадаадын 8500, дотоодын 100000 орчим аялагчид эвент арга хэмжээнүүдийг үзэж сонирхохоор зорин ирснээр 1.0 тэрбум гаруй төгрөгийн борлуулалтын орлогыг орон нутгийн иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд олсон байна. Аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор байгалийн, рашаан сувиллын, түүх соёлын контент хийхэд 40.0 сая төгрөг зарцуулан 3 төрлийн 7 контент, видео бичлэг хийв. Мөн аймгийн аялал жуулчлалын нэгдсэн дижитал платформ, хөгжүүлэх зорилго бүхий "visitbulgan.mn" веб сайтыг 44.2 сая төгрөгөөр "Ай Өү технологи" ХХК гүйцэтгэн 2023 онд хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. Аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор байгалийн үзэсгэлэнт, түүх соёлын дурсгалт газрууд болон музейн үзмэрүүдийн виртуал танилцуулгыг "Дижитал сольюшнс" ХХК 24.5 сая төгрөгөөр гүйцэтгэж, жуулчид, аялагчдад зориулсан газрын зураг, танилцуулгыг шинэчлэн гаргах ажлын гүйцэтгэгчээр "МРМ" ХХК шалгарч, 14.7 сая төгрөгөөр англи, монгол хэлээр 6500 ширхэгийг хэвлэн, хүлээлгэж өгсөн.	92.5
3.2.2	Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх санал санаачилгыг дэмжин, хамтран ажиллана.	Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор 12 дугаар сард өвлийн спортын бага наадмыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Тус ажлын хүрээнд 5.0 сая төгрөгийг аймгийн төсөвт батлуулсан.	100
3.2.3	"Чингийн цагаан нуур"-ын орчимд "Ус, намгархаг газрын мэдээллийн төв" байгуулж, нүүдлийн шувуу, ховор ан амьтан ажиглах, тусгай сонирхлын аялал жуулчлалыг бий болгоно.	Дашинчилэн сум уг төслийг хэрэгжүүлэх газрын асуудлаа шийдвэрлүүлэхээр ИНХ-аар хэлэлцүүлсэн боловч иргэд эсэргүүцсэн тул төсөл хэрэгжүүлэх боломжгүй болсон.	0
3.2.4	Улсын болон орон нутгийн чанартай авто зам дагуу стандартад нийцсэн түр буудаллах цэг байгуулна.	2021 онд Хутаг-Өндөр сумын Дондогийн булагт улсын төсвийн 400.0 сая төгрөгийн хөрөнгөөр түр буудаллах цэгийг "Сувдан элс" ХХК барьж, энэ оны 5 дугаар сард хүлээлгэн өгсөн. Мөн 2022 онд улсын төсвийн 200.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Рашаант сумын Элсэн тасархайд "Өвөлжөөн булаг" ХХК, Баян-Агт сумын Хануй рашааны дэнж дээр "Цонхот" ХХК отоглох цэг байгуулах ажлыг гүйцэтгэн хүлээлгэж өгөв.	100
3.3. Уул уурхай. Уул уурхайн салбарт экологийн болон нийгмийн хариуцлагын тогтолцоог бий болгон нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, аймгийн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.			
3.3.1	Ашигт малтмалын олборлох, боловсруулах үйлдвэрлэлд хүний эрүүл мэнд, байгаль орчны сөрөг нөлөөлөл багатай дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж, аюулгүй ажиллагааг хангасан ил тод, хариуцлагатай уул уурхайг бий болгоно.	Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд Ашигт малтмал, газрын тосны газраас манай аймагт 2022 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр "Эрдэс баялгийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудал, шийдэл" хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт холбогдох төрийн байгууллагууд болон уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл 51 хүн оролцлоо. Үүнтэй холбогдуулан аймгийн Засаг дарга болон Бүрэгхангай, Дашинчилэн сумын Засаг дарга нар уул уурхайн 10 аж ахуйн нэгжтэй байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай хамтын ажиллагааны гэрээг байгуулж, 33 хүүхдийн сургалтын төлбөр, 3 хүүхдийн эмчилгээний зардал болох 224.0 сая төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэхээр тогтож, одоогийн байдлаар 164.0 сая төгрөг, 30 хүүхдийн сургалтын төлбөрийг төвлөрүүлээд байна. Бүрэгхангай сум 2022 онд 15 уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүдтэй нийгмийн хариуцлагын гэрээг байгуулан 938.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 541.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. 2022 онд уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгч "Фокус метал майнинг" ХХК болон "Батбродерс" ХХК шинээр усны тоолуур суурилуулав.	95.0
3.3.2	Уул уурхайн олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлж, үйл ажиллагааг тогтмолжуулна.	Сайхан сумын нутагт орших "Эрээний ихэр уул" нэртэй 65.59 га талбай бүхий ашигт малтмалын MV-014228 дугаар ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Илчит металл" ХХК-ийн Эрээний чулуун нүүрсний орд нь 659501.9 тонн нөөцтэй бөгөөд 2022 оноос үйл ажиллагаа явуулж эхэлсэн. "Нүүдэлчин Айрон ресорс" ХХК-ийн MV-017539, "Фокус метал майнинг" ХХК-ийн MV-021708, MV-015152, MV-012263 тоот тусгай зөвшөөрөл бүхий "Өлзийт-Овоо", "Захцаг уул", "Худаг байшинтын орд", ыг олборлон, боловсруулах ажлыг явуулсан.	100

3.3.3	Уул уурхайн олборлолтын болон барилга, авто зам, дэд бүтэц, бүтээн байгуулалтын улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээнэ.	Дашинчилэн сумын Доргонот багийн "Цагаан чулуут" гэх газар гар аргаар алт олборлосон, эвдэрсэн 1.8 га газрыг нөхөн сэргээх ажлыг "Батбродерс майнинг" ХХК-аар гүйцэтгүүлээ. Бүрэгхангай сумын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд уул уурхайн олборлолтын улмаас эвдэрч эзэнгүй орхигдсон 41 га газарт нөхөн сэргээлтийн ажлыг төлөвлөснөөс биологийн нөхөн сэргээлтийг 12.1 га, техникийн нөхөн сэргээлтийг 31.5 га талбайд хийв. 2022 онд Дашинчилэн суманд "Өвөр хадат" гэх газарт 2, "Овоо" гэх газарт 2, Бүрэгхангай сумын "Цоохор морьт" гэх газарт 2, "Наран гоулд" ХХК-ийн талбайд хууль бус алт олборлолтын 1 хэрэг гарч, 29.5 сая төгрөгийн хохирол тогтоолгох ажил хийгдсэн байна.	100
3.4 Дэд бүтэц. Аймгийн дэд бүтцийн салбарыг хөгжүүлж, иргэдийн ая тухтай амьдрах орчныг бүрдүүлнэ.			
3.4.1	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хөгжлийн хэтийн зорилт, хот төлөвлөлттэй уялдуулан газар олголтын үйл ажиллагааг ил тод болгоно.	Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу "Вектор мэн" ХХК 2019-2021 оны хооронд аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулан 2022 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын IX хуралдаанд хэлэлцүүлж, 2022 оны IX/18 дугаар тогтоолоор баталгаажуулан газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд оруулах ажлыг гүйцэтгэж, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100
3.4.2	Булган хотын ерөнхий төлөвлөгөөг /ногоон хот төлөвлөлт/ шинэчлэн боловсруулж, зарим сум, багийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хийнэ.	Аймгийн төвийн Булган сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төлөвлөлтийн ажил дуусаж, шат шатны мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэгдэн аймгийн ИТХ-ын 2022.03.29-ний өдрийн IX/19 дүгээр тогтоолоор батлуулж, Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. Тус яамны сайдын зөвлөл болон магадлалын хурлаар хэлэлцүүлэн хот төлөвлөлтийн нэгдсэн системд оруулан төлөвлөгөөг мөрдөн ажиллаж байна. Бугат сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр "Эрхэт констракшн" ХХК шалгарч, ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажлыг гүйцэтгэж байна.	85.0
3.4.3	Аймгийн инженерийн хийцтэй барилга байгууламжуудад үнэлгээ хийж, барилгын засвар, дулаалгын ажлын эрэмбийг тогтоож, хэрэгжүүлнэ.	Орон нутгийн 2022 оны төсөвт 50.0 сая төгрөг тусган Булган сумын Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дадлагын байр, Эрдмийн Өргөө цогцолбор сургуулийн хичээлийн байрны 1-р блок, Сайхан сумын сургуулийн хичээлийн байр, Бугат сумын Засаг даргын Тамгын газрын барилга, Хялганат тосгоны Соёлын төв, Эрүүл мэндийн төв, Захирагчийн ажлын албаны барилга, Сэлэнгэ сумын сургуулийн хичээлийн байр, Могод сумын Соёлын төв гэсэн 9 барилгыг паспортжуулахаар даалгавар боловсруулсан. Гүйцэтгэгчээр шалгарсан "Бүүвэй цагаан барс" ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан хяналт тавин ажиллаж байна. "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газар болон орон нутгийн төсвийн 360.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Булган сумын 12, 14, 15, 18а, 18б байрны барилгын гадна ханын засварын ажлыг хийж гүйцэтгэн ашиглалтад орууллаа.	100
3.4.4	"Сайн хашаа", "Гудамж" төслүүдийн төлөвлөлтийг боловсруулж, бүтээн байгуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	Булган сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төлөвлөлтийн ажил дуусаж, шат шатны мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэгдэн аймгийн ИТХ-ын 2022.03.29-ний өдрийн IX/19 дүгээр тогтоолоор батлуулж, Барилга, хот байгуулалтын яамны сайдын зөвлөлийн хурал болон магадлалаар хянуулж, хот төлөвлөлтийн нэгдсэн системд оруулсан. Булган сумын Засаг даргын Тамгын газартай хамтран "Сайн хашаа", "Гудамж" төслийг үе шаттайгаар хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, төслийг хэрэгжүүлэх ажлын зураг төсвийн даалгаврыг боловсруулж байна. Хөдөө сумын төв бүрд сумын төвийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан "Сайн хашаа" төслийг үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөж, ажлын даалгаврыг боловсруулсан.	70.0

3.4.5	Аймгийн Хүүхэд залуучуудын соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажлыг ерөнхий төлөвлөгөөний дагуу барьж дуусган, сум суурин газарт спортын болон хүүхдийн тоглоомын талбай бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж, төв, суурин газрын ногоон байгууламжийг 50 хувиар нэмэгдүүлнэ.	Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн 2-р шатны иж бүрэн ажлын зураг төслийг Булган хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөж, 2019 онд гүйцэтгүүлсэн. Төсөв шинэчлэх асуудлаар тухайн зураг төсвийн зохиогчтой зөвшилцөн гэрээний дагуу шинэчлүүлж байгаа бөгөөд 2023-2024 онд үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Баяннуур, Бүрэгхангай, Гурванбулаг, Сайхан, Хишиг-Өндөр суманд 2021-2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хүүхдийн тоглоомын талбай байгуулж, Бүрэгхангай, Гурванбулаг, Сайхан, Хишиг-Өндөр сумын хүүхдийн тоглоомын талбайг улсын комисс байнгын ашиглалтад хүлээн авсан. Баяннуур сумын хүүхдийн тоглоомын талбайг Барилгын хөгжлийн төвтэй хамтран гүйцэтгэгч "Роял алтай констракшн" ХХК алданги тооцож, явган замын бетоны ажил, тоглоомыг суурилуулж дуусгахаар зөвшилцөж, ажлыг үргэлжүүлж байна. Төв суурингийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 1.5 км газарт 12 нэр төрлийн 8 өнгийн 12600 ширхэг цэцгийн үрсэлгээг хийж арчлан 100 хувь ургуулсан. Булган сумын 18 дугаар байрны орчим 300 м.кв талбайд шинээр хамгаалалтын торон хайсыг хийж, зүлэгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэсэн байна. Мөн хуучин зүлэгжүүлсэн талбайн халцарсан 100 м.кв талбайд нөхөн тарилт хийж арчилгаа хийв. Аймгийн хэмжээнд "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 1513 өрх 26692 ширхэг мод тарьж, ногоон байгууламжид 461 аж ахуйн нэгжийн 133687 ширхэг мод, 52300 м.кв талбайг хашин хамгаалж, зүлэгжүүлэн мод тарьж, 628.6 сая төгрөг зарцуулан ногоон байгууламжийг нэмэгдүүллээ. Дээрх ажлуудын дүнд төв суурин газруудын ногоон байгууламжийн хэмжээ 15.0 хувиар нэмэгдээд байна.	100
3.4.6	Булган сумын гэр хорооллын гудамж, талбайг бүрэн гэрэлтүүлэгтэй болгоно.	Булган сумын 1, 4, 6 дугаар багийн гэр хорооллын гэрэлтүүлгийн ажлыг орон нутгийн төсвийн 380.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр "Сервис по сименс" ХХК шалгарч, угсралтын ажлыг гүйцэтгэн ашиглалтад оруулж, гэр хорооллын нийт гэрэлтүүлгийг 10.0 хувьд хүргэлээ.	100
3.4.7	Булган сумын Зүүнтүрүү багийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар төвлөрсөн дулаан хангамжтай болгоно.	Булган сумын 4-р баг Зүүн түрүүний хэсэгт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийх даалгавар боловсруулан "Эрхэт констракшн" ХХК-тай 20.0 сая төгрөгийн гэрээ байгуулан ажиллаж байна. Уг төлөвлөгөөний дагуу тухайн хэсэгт хийгдэх инженерийн нэгдсэн шугам сүлжээ /дулаан, цэвэр, бохир, цахилгаан, холбоо/-ний нэгдсэн төлөвлөлт, трасс батлагдана. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний төлөвлөлт хийгдсэний дараа хөрөнгө оруулалтын ажлыг үе шаттайгаар төлөвлөн хэрэгжүүлнэ.	-
3.4.8	Аймгийн төвийн хэрэглэгчдийг хэрэглээний халуун устай болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.	Булган сумын айл өрх, аж ахуйн нэгжийг үе шаттайгаар хэрэгцээний халуун усны шугамд холбох ажлын хүрээнд 2 болон 5 дугаар УДДТ-ийн үйлчилгээний хүрээний нийтийн орон сууц, төр төсвийн байгууллагыг хэрэгцээний халуун усны шугамд холбох ажлын зураг төслийг "Онолт од" ХХК гүйцэтгэсэн бөгөөд 2021 онд аймгийн орон нутгийн төсвийн 348.0 сая төгрөгөөр "Нью гранд пропертиз" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэв. Тус ажлын хүрээнд 1, 6 дугаар цэцэрлэг, 18а, 18б байрны хэрэгцээний халуун усны шугамын угсралтын ажил дуусаж, 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдөр ашиглалтад хүлээлгэж өгсөн. 2022 онд 2 дугаар шатны ажилд аймгийн орон нутгийн төсвийн 350.0 сая төгрөгөөр 14, 15, 22, 23 дугаар нийтийн орон сууцыг холбож, ашиглалтад оруулсан.	100
3.4.9	Орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийг сайжруулна.	Хялганат тосгоны төвийн 10 км авто замын гүйцэтгэгчээр "Увт инвест" ХХК ажиллаж байгаа бөгөөд замын ажил дуусаж, явган замын хавтан суулгах, гэрэлтүүлгийн ажил хийгдэж байна. Дашинчилэн сумын 1.8 км авто замын төсвийг 2022 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгаж, замын ажлын гүйцэтгэгчээр "Оффрөүд таван богд" ХХК шалгарч, зам тээврийн хөгжлийн төвтэй 1.49 тэрбум төгрөгөөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, энэ оны төсөвт тусгагдсан 800.0 сая төгрөгөөр замын ажлын эхлүүлсэн ба гүйцэтгэл 20.0 хувьтай байна. Аймгийн авто замын сангийн 280.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Бугат сумын төвд 2.2 км, Орхон сумын төвд 2.8 км хатуу хучилттай авто замын ажлыг тус тус гүйцэтгэхээр "Булган АЗЗА" төрийн өмчит хувьцаат компани шалгаран ажлыг гүйцэтгэж байна.	80.0
3.4.10	Булган суманд нийтийн тээврийн автобусны үйлчилгээг тогтмолжуулж, сурагчдын автобустай болгоно.	Булган сумын нийтийн эзэмшлийн авто зогсоолын хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Булган сумын 5 дугаар баг "Өнө мандал" дэлгүүрийн урд талд 865 м.кв бетон авто зогсоолын талбай, явган хүний зам тавьж, байнгын ашиглалтад оруулсан. Дээрх ажлын гүйцэтгэгчээр "Арвин ган бумба" ХХК, "Ариун ганга бумба" ХХК-иуд ажилласан бөгөөд Булган сумын Засаг даргын Тамгын газартай 75.0 сая төгрөгөөр гэрээ байгуулан ажиллав.	90.0
3.4.11	Ерөнхий зориулалтын бага оврын агаарын хөлгийн байнгын нислэг бий болгоно.	Улаанбаатар-Булган чиглэлд бага оврын агаарын хөлгийн байнгын нислэгийг үйлдэхээр Иргэний нисэхийн ерөнхий газар болон Монголын иргэний агаарын тээвэр ХХК-д хамтран ажиллах санал хүргүүлээд байна.	30.0

4.1. "Цахим Монгол" төрийн шуурхай үйлчилгээ. Цахим хөгжлийн бодлогыг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа зардлыг хэмнэнэ.			
4.1.1	"Цахим Монгол" төрийн үйлчилгээг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлнэ.	Цахим гарын үсгийн тухай хуулийн дагуу аймгийн хэмжээнд 500 гаруй төрийн албан хаагч, 1842 иргэн, 16 сумын 325 аж ахуйн нэгж, байгууллагад тоон гарын үсэг олгосноор төрийн 800 гаруй үйлчилгээг тоон гарын үсэг ашиглан авах боломжтой боллоо. E-Mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн системийг 16 суманд бүрэн нэвтрүүлсэн. Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх "SMART BULGAN" гар утасны аппликэйшнийг хэрэглээнд нэвтрүүлж, уг аппликэйшнээр аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын үйл ажиллагаа, төрийн бодлого шийдвэр, үйл ажиллагааны мэдээ мэдээллийг иргэдэд түгээх, иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авах боломжтой боллоо. Нийгмийн даатгалын үйлчилгээнд тус газрын 18 төрлийн үйлчилгээ, Ehalamj.mn системээр 40 төрлийн үйлчилгээг тус тус цахимжуулсан байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Г блокийг "E-Mongolia" төрийн үйлчилгээний нэгдсэн төв болгохоор 247.6 сая төгрөгөөр засвар үйлчилгээг хийж, 64.8 сая төгрөгийн техник хэрэгслээр хангасан. Тус төвийг нээснээр төрийн үйлчилгээг иргэдэд дараалалгүй, түргэн шуурхай, цахимаар үйлчилж эхэллээ.	100
4.1.2	Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд олон нийтийн оролцоог хангана.	Аймгийн вэб сайт бүрэн шинэчлэгдэж, сумдын вэб сайтуудыг шинэчлэх ажил шат дараатайгаар хийгдэж байна. Вэб сайтаар иргэд олон нийт байгууллагаас гарч буй бодлого шийдвэрийн талаарх мэдээллийг авч хэвшээд байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар аймгийн вэб сайт /bulgan.gov.mn/-д 1800 мянга гаруй иргэн хандаж мэдээлэл авчээ. Энэ онд 15 байгууллага, 8 сум вэб сайтаа шинэчлэн идэвхтэй ажиллуулж байгаа ба төсөв санхүүгээс шалтгаалан 8 байгууллага, 8 сум шинэчлэлт хийгдээгүй байна.	50.0
4.2. Мэргэшсэн, ёс зүйтэй төрийн алба-хүнд сурталгүй төрийн үйлчилгээ. Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ.			
4.2.1	Төр, иргэний нийгмийн байгууллагын түншлэлийг бэхжүүлж, шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, эрх ашгийг дээдэлсэн зөв бодлогыг хэрэгжүүлнэ.	Төр, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд 2022 онд аймгийн хэмжээнд 30 төрийн бус байгууллагатай хамтран 36 ажил, арга хэмжээг зохион байгууллаа. Төр, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг эрчимжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахаар аймгийн Засаг даргын 2022 оны А/68 дугаар захирамжаар удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилон үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллаж байна. Мөн 11 дүгээр сард төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн манлайлал сургалтыг зохион байгуулж, 23 агентлаг, 2 сумаас 60 төрийн албан хаагч эмэгтэйг хамруулав. Захиргааны хэм хэмжээний актыг боловсруулахдаа Монгол улсын хууль болон бусад хуулинд заасны дагуу иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 32 удаагийн хэлэлцүүлэг, 7 удаагийн нийтийн сонсгол зохион байгуулж, давхардсан тоогоор 6200 иргэнийг оролцууллаа.	100
4.2.2	Төрийн албаны хүний нөөцийг үе шаттай сургаж, мэргэшүүлэн төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл боломжийг сайжруулж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ.	"Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам"-ыг баримтлан төрийн жинхэнэ албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг 4 удаа зохион байгуулж, төрийн захиргааны 149, төрийн үйлчилгээний 17 албан хаагчийг шинээр томилон ажиллуулж байна. Өмнөх онтой харьцуулахад томилгооны зөрчил 18 хувиар буурсан байна. Төрийн албаны ерөнхий шалгалт 2 удаа зарлагдаж 78 хүн төрийн албаны нөөцөд бүртгэгдлээ. Төрийн байгууллагын хүний нөөцийг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчдыг сургаж, мэргэшүүлэх, чадваржуулах, төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, орон нутагт төрийн албан хаагчийг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор "Аймгийн төрийн албаны хүний нөөцийг 2023-2028 онд хөгжүүлэх хөтөлбөр"-ийг аймгийн ИТХ-аар батлуулан шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгахаар ажиллаж байна. Төрийн албаны үйл ажиллагаанд ахиц дэвшил гаргах зорилгоор 2022 оныг "Ёс зүйтэй, мэдлэг чадвартай, хариуцлагатай-Төрийн алба"-ны жил болгон зарлалаа. Жилийн ажлын хүрээнд аймгийн болон сумдын "Төрийн албан хаагчдын зөвлөгөөн"-үүдийг зохион байгуулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Удирдлагын академи, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Нэгдсэн үндэстний байгууллагын "Монгол улсад мэргэжлийн иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь" төсөл зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж, мэргэшүүлэх, чадваржуулах, ёс зүйн сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулав. Удирдлагын академийн богино болон дунд хугацааны, мэргэшүүлэх багц сургалт, ахлах болон эрхэлсэн түшмэлийн сургалтад 93 албан хаагч суралцаж байгаагаас гадна 8 байгууллагын 8 төрийн албан хаагчийг хууль, тогтоомжийн хүрээнд шилжүүлэн ажиллуулж байна.	91.7

4.2.3	Төрийн байгууллагад хандсан иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг цахимаар хүлээн авч шуурхай шийдвэрлэнэ.	Аймгийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг шийдвэрлэхдээ "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" хууль, Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар батлагдсан нээлттэй утас, саналын хайрцаг ажиллуулах журам болон иргэдээс тавьсан асуудалтай холбоотой хууль тогтоомж, бусад эрх зүйн баримт бичиг, дүрэм журмыг баримтлан ажиллаж байна. Цахим засаглал бодлогын хүрээнд иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл хүсэлтийг цаг хугацаа орон зайнаас үл хамааран гаргах нөхцөл боломжийг бүрдүүлж, аймгийн Засаг даргын Тамгын газар, 8 сумын Засаг даргын Тамгын газар, 15 агентлаг байгууллагын албан ёсны цахим хуудаст өргөдөл гомдол хүлээж авах цэс бий болгосон.	70.0
4.2.4	Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулна.	Төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн төрийн сангийн үйл ажиллагааг цахимжуулж, 156 төсөвт байгууллагын цалингийн гүйлгээг "Төрийн албаны цалингийн нэгдсэн систем"-д бүрэн хамрууллаа.	100
4.2.5	Төрийн бүх шатанд байгаа авлигыг таслан зогсоох, авлигаас урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээнүүдийг зохион байгуулж, төр иргэдийн энэ төрлийн мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлнэ.	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн 15 сум, 1 тосгоны 616 төрийн алба хаагч, ерөнхий боловсролын сургуулийн 475 сурагч, Булган сумын 23 төрийн байгууллагын 1195 алба хаагч нарт Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүй, Авлигын тухай ойлголт, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 41 удаагийн сургалтыг хийсэн. Мөн авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг "Булганы өнгө" ТББ-аар гүйцэтгүүлэхээр хамтран ажиллах гэрээ байгуулж, ерөнхий боловсролын сургуулийн 160 сурагч, 200 иргэн, 250 төрийн албан хаагч нарт сургалт, мэдээлэл өгсөн байна. Төрийн байгууллагуудын шударга байдлын үнэлгээ хийлгэхээр "Хотуга" болон "Булганы өнгө" төрийн бус байгууллагатай гэрээ байгуулж, Булган сумын Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн газарт судалгааны ажил хийгдсэн. Судалгааны дүгнэлтийг үндэслэн тус 2 байгууллагад аймгийн Засаг даргын ажлын чиглэл хүргүүлэв.	60.0
4.2.6	Аймгийн ЗДТГ-ын дэргэд Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийг шинээр байгуулна.	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Г блокыг "E-Mongolia" төрийн үйлчилгээний нэгдсэн төв болгох хүрээнд 247.6 сая төгрөгөөр засвар үйлчилгээг хийж, 64.8 сая төгрөгийн техник хэрэгслээр хангасан. Тус төвийг нээснээр төрийн үйлчилгээг иргэдэд дараалалгүй, түргэн шуурхай, үзүүлж эхэллээ.	100
4.2.7	MNS ISO 9001:2016 "Чанарын менежментийн тогтолцоо - шаардлагатай стандарт" төрийн байгууллагуудад нэвтрүүлнэ.	Бүрэгхангай сумын Засаг даргын Тамгын газар MNS ISO 9001:2016 стандарт нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлж, зөвлөх үйлчилгээний "Тэнүүн сэтгэмж" ХХК, баталгаажуулалтын "КЮ СЕРТФ" ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж, 11 дүгээр сард эхний шатны аудит хийгдсэн бөгөөд гэрээний дагуу 2022 онд багтан баталгаажуулалт хийгдэнэ. Мөн Тэшиг сумын Засаг даргын Тамгын газар стандарт нэвтрүүлэх ажлыг 6 дугаар сард эхлүүлж, "Эйч эс и кью консалтанси" ХХК-тай хамтран ажиллаж, 2 шатны сургалтад хамрагдсан байна. Гэрээ, төлөвлөгөөний дагуу нэвтрүүлэх ажлыг амжилттай хэрэгжүүлж байна. Аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс нь Стандар, хэмжил зүйн газартай хамтран MNS ISO 9001:2016 "Чанарын менежментийн тогтолцоо-шаардлага стандарт"-ын мэдлэг олгох сургалтыг 5 сум, 1 тосгон, 20 төрийн байгууллага, 1 аж ахуйн нэгжийн 115 ажилтныг хамруулан зохион байгууллаа.	100

4.2.8	Уламжлалт харилцаат ОХУ, БНХАУ болон өндөр хөгжилтэй Япон, БНСУ, АНУ, БНТУ, БНБеларусь, Чех зэрэг улстай эдийн засгийн үр ашиг бүхий гадаад хамтын ажиллагааг хөгжүүлнэ.	<p>БНСУ-ын Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага /KOICA/-тай 3-5 жилийн хугацаанд Булган аймагт аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, тохижилт үйлчилгээг сайжруулах, бага дунд орлоготой өрхүүдийг дэмжих, сургалт явуулах, хөдөө аж ахуйн болон гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэлд солонгос технологийг нэвтрүүлэх зэрэг ажлуудыг хэрэгжүүлж эхэллээ. Булган аймаг БНСУ-ын Кёнгү аймагтай хамтын ажиллагааны, Баяннуур сум БНСУ-ын Сөүл хотын Кангбүг дүүрэгтэй найрамдалт харилцааны, аймгийн Нэгдсэн эмнэлэг Солонгос улсын СОН-Э эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээг тус тус байгуулав.</p> <p>АНУ-ын Элчин сайдын яам болон Монгол дахь Америкт төгсөгчдийн холбооны төлөөлөл, "Education USA Mongolia" хөтөлбөрийн зөвлөх баг манай аймагт ажиллаж, хөтөлбөрийн үйл ажиллагааны танилцуулга, тэтгэлэгт хөтөлбөрийн мэдээлэл хийж, ЕБС-ийн 30 гаруй сургалтын менежер, англи хэлний багш нарт заах арга зүйн сургалт орсон нь аймгийн англи хэлний багш, сурагчдын мэдлэг, ур чадварыг хөгжүүлэхэд сайн үр дүн авчирлаа. АНУ-аас хамтын ажиллагааны хүрээнд англи хэлний мэргэжилтэн багш ажиллахаар ирснээр англи хэлний багш нарыг чадавхжуулах хөтөлбөр хэрэгжүүлэхээс гадна сурагчид, төрийн албан хаагчдад зориулсан зорилтот сургалтуудыг үнэ төлбөргүйгээр явуулж эхэлсэн. Тус улсын Иргэн цэргийн дэмжлэгийн бүлэг ОБЕГ-тай хамтран Булган аймагт "Өндрөөс аврах ажиллагаа"-ны 14 хоногийн дадлага сургуулилтыг зохион байгуулсан.</p> <p>Бүгд Найрамдах Беларусь улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд тэргүүтэй төлөөлөгчид Булган аймагт, аймгийн Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг Беларусь улсад албан ёсны айлчлал хийж хамтран ажиллах санамж бичиг байгуулснаар манай аймгийн 3 оюутан Беларусь улсын Жодино хотын Политехникийн коллежид "Юнайтед белаз машинери" ХХК-ийн 100 хувийн тэтгэлгээр суралцаж эхэллээ.</p> <p>Аймгийн ИТХ-ын дарга тэргүүтэй төлөөлөгчид Унгар, Чех улсад албан айлчлал хийж, айлчлалын хүрээнд Булган сум Унгар улсын Эгер хоттой хамтын ажиллагаатай хот болж, ажлын байр нэмэгдүүлэх, дадлагажигч бэлтгэх урьдчилсан хэлэлцээрийг хийв. Төлөөлөгчид Чех улсын "Фенип" корпорацийн үйл ажиллагаа, бүтээн байгуулалттай танилцаж, Булган аймагт иргэдийн орлого, эдийн засагт тохирсон үнэ бүхий евро стандартын орон сууцыг Булган суманд барих асуудлыг шийдэж, Чех улсын "Контехин" группын үүсгэн байгуулагч тэргүүтэй төлөөлөгчид Булган аймагт айлчилж, барилгын ханын дулаалгын үйлдвэр, шар айрагны үйлдвэр барих асуудлаар албан уулзалт хийж, санал солилцон барилгын дулаалгын материал хийхэд шаардагдах түүхий эдийн дээжийг авч, судалгааны ажил хийгдэж эхэллээ.</p>	100
4.3. Хууль, эрх зүй, батлан хамгаалах. Иргэдийн аюулгүй амар тайван байдлыг хангана.			
4.3.1	Аймгийн төв болон сумын төвийн камержуулалтын нэгдсэн системийг шинэчлэн засварлаж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох арга хэмжээг авч, гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулж, нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангана.	<p>Аймгийн төвийн хяналтын камерыг шинэчлэх, засвар үйлчилгээ хийх ажлын хүрээнд орон нутгийн төсвийн 50.0 сая төгрөгөөр гудамж талбайд шинээр 25 ширхэг камер суурилуулах, шилэн кабелийн мүүфт засвар үйлчилгээг хийлгэх, Зоон давааны зам тээврийн хяналтын постонд тээврийн хэрэгслийн дугаар бичигчтэй ANPR камер авахаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад "Хотпот сервис" ХХК шалгарч, угсралтын ажлыг гүйцэтгэж байна. Дээрх камеруудыг суурилуулснаар аймгийн төвд 33 байршилд 86 камераас 64 камер хэвийн ажиллана.</p> <p>Бүрэгхангай сумын төвд сум хөгжүүлэх сангийн 9.0 сая төгрөгөөр 6 ширхэг камерыг шинээр суурилуулж, Тэшиг сумын Эгийн голын гүүрэн гарцны хяналтын камер, төв серверийн төхөөрөмжийг сум хөгжүүлэх сангийн 7.5 сая төгрөгөөр засварлав. Орхон сумын гүүрэн гарцны хяналтын камер, Зоон давааны хяналтын 2 камерт засвар үйлчилгээ хийж, Хангал сумын Хялганат тосгоны гүүрэн гарцны 2 ширхэг камер, тосгоны төвд ашиглагдаж байсан 1 камерыг засварлаж, хэвийн ажиллагаанд оруулсан. Орон нутгийн төсвийн 10.2 сая төгрөгөөр Рашаант сумын зам тээврийн хяналтын постонд дугаар бичигчтэй 2 ширхэг ANPR камерыг энэ оны 10 дугаар сард шинээр суурилуулж, үйл ажиллагаандаа ашиглаж байна. Дээрх газруудыг теле хяналтын камерын системд холбосноор гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, иргэдийн аюулгүй байдлыг хангах ажилд үр дүнгээ өгч байна.</p> <p>Мал хулгайлах гэмт хэргийн гаралтыг бууруулах, илрүүлэлтийг дээшлүүлэх зорилгоор хил залгаа аймаг, сумдын Цагдаагийн газар, албан хаагчидтай хамтран 11 удаа хяналт шалгалтыг зохион байгуулан ажиллалаа. Мөн аймгийн хэмжээнд мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутгийн төсвийн 7.0 сая төгрөгөөр "Цагаан сар", "Оюутан", "Мал мах" зэрэг нэгдсэн арга хэмжээг зохион байгуулан ажилласан. Аймгийн хэмжээнд нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангах чиглэлээр орон нутгийн төсвийн 10.0 сая төгрөгөөр нэгдсэн 7, хэсэгчилсэн 8 арга хэмжээг зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд энэ онд мал хулгайлах гэмт хэрэг 46 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 4 хэргээг өсөж, хэргийн илрүүлэлт 65.9 хувь буюу өмнөх оноос 22.0 хувиар өссөн байна. Мөн нийт 467 гэмт хэрэг бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 16.9 хувиар, илрүүлэлт 55.3 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 0.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.</p>	95.0

4.3.2	Мансууруулах бодис хэрэглэгч, архинд донтогчдод эрүүл мэндийн болон сэтгэл зүйн засал, нийгмийн тусламж үйлчилгээг үзүүлэх, урьдчилан сэргийлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	<p>“Зөв дадал-Архигүй орчин” хөтөлбөрийн хүрээнд аймгийн 16 сумын Засаг даргын Тамгын газар, тосгоны Захирагчийн ажлын алба, “Катарсис” сэтгэл зүйн зөвлөгөө заслын эмнэлэг хамтран сэтгэл зүйн эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг зохион байгууллаа. Төрийн албан хаагчдын өс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх, архидалт согтуурлын хор холбогдлыг таниулах, сэтгэл зүйн эрүүл мэндийн боловсрол олгохоор “Далд ухамсрын хүч”, “Ойлгоё, тусалъя” сэдэвт сургалт, лекц хийж, 1315 албан хаагч хамрагдсан байна. Архины хамааралтай иргэдийг оношлох, зөвлөгөө өгөх ажлыг сумдын Цагдаагийн хэсэгтэй хамтран зохион байгуулж, 175 иргэн, тэдний гэр бүлд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлээ. Мөн байнга архидан согтуурдаг архины хамаарал бүхий 11 иргэнийг Шүүхийн шийдвэрээр 3 сарын албадан эмчилгээнд хамруулахаар Төв аймгийн Баян сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа согтуурах, мансуурах донтой этгээдийг албадан эмчлэх төвд хүлээлгэн өгөв. Аймгийн нэгдсэн эмнэлэгт архины хордлого болон архинд донтох өвчтэй 9 иргэн хэвтэн эмчлүүлсэн. Сайн дурын эмчилгээнд 30 гэр бүл, архинаас гаргах сэтгэл заслын минесота загварын эмчилгээний 20 хоногийн хөтөлбөрт Бугат, Могод, Тэшиг сумаас 20 иргэн гэр бүлийн хамт тус хамрагдаж, 20 гэр бүл, 5 иргэн согтууруулах ундаа дахин хэрэглээгүй үр дүнтэй байна. Катарсис, Гэрэлт ирээдүй оршихуй, Буйлхан ногоон төгөл зэрэг төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагаа сайжирч, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх АА цуглааны үйл ажиллагааг Бугат, Булган, Тэшиг, Хутаг-Өндөр сумын Уньт баг, Бугат сумын Төлүүгийн даваа гэх газарт идэвхтэй явуулж эхэлсэн. Энэ оны 09 дүгээр сард аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар “Зөв дадал-Архигүй орчин” хөтөлбөрийн хэрэгжилтийг хэлэлцүүлсэн ба хөтөлбөрийн 2022 оны үйл ажиллагааг 3 зорилт, 11 шалгуур үзүүлэлтээр дүгнэж үзэхэд 92.4 хувийн хэрэгжилттэй байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс 10.0 сая төгрөг зарцуулсан. Тус хөтөлбөрийн үр дүнд 2022 онд аймгийн хэмжээнд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 121 бүртгэгдэж 14 нэгжээр буюу 10.4 хувиар буурсан.</p> <p>Аймгийн хэмжээнд мансууруулах, донтуулах үйлчилгээний /каннабис/ төрлийн ургамлын тархац тогтоогдсон нэр бүхий 5 сумын нутаг дэвсгэрт зэрлэг байдлаар ургаж буй ургамлын тархацыг зогсоох, устгалын ажлыг 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс 07 дугаар сарын 07-ны өдрийн хооронд 1240 га талбайг хамруулан зохион байгуулсан. “Устгал - 2022” нэгдсэн арга хэмжээнд шаардагдах 6.0 сая төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлэн ажиллав. Энэ онд мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг хууль бусаар тариалах гэмт хэрэг бүртгэгдээгүй, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг 1 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй адил түвшинд байна.</p>	100
4.3.3	Зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй бодлогыг хэрэгжүүлэх замаар замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, зам тээврийн осол, түүнээс үүдэх хор уршгийг бууруулна.	<p>Аймгийн хэмжээнд “Зөвийг хэвшүүлье” уриатай хэрэгжүүлж байгаа “Уусан бол бүү жолоод”, “Гэрлээ анхааруулъя”, “Гар утас”, “Сургууль орчмын бүс”, “Аажуу явбал аяндаа хүрнэ дээ”, “Хүүхдийн суудал”, “Ядарсан үедээ жолоо бүү барь”, “Дугуй”, “Хамгаалалтын малгай” нөлөөллийн арга хэмжээ, техник хяналтын чиглэлээр “Ачааны автомашины бүрэн бүтэн байдал”, “Ачаа тээвэр”, “Тээврийн хэрэгслийн өнгөт хальс-тень”, “Арлын дугаар-2022”, “Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал-Оношилгоо” зэрэг тусгай арга хэмжээг зохион байгуулав.</p> <p>Зам тээврийн осол, хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах төлөвлөгөө боловсруулан 4 танилцуулга, 4 саналыг холбогдох байгууллагуудад хүргүүлж, 32 удаагийн сургалтад 3458 хүн хамруулан 2 нөлөөллийн арга хэмжээ, 1 подкаст, 2 видео контент, 10 мэдээлэл, зөвлөмж, телевизийн 7 сэрэмжлүүлэг мэдээ, 38 төрлийн мэдээ, мэдээллийг цахим сайтад байршуулж, 8 төрлийн 4810 санамж, сэрэмжлүүлэг тарааж, 15 мэдэгдэл шаардлага өгч, давхардсан тоогоор 69 удаагийн 4535 иргэн, хүүхэд багачуудад сургалт зохион байгуулсан. Дээрх ажлуудад орон нутгийн төсвөөс 5.0 сая төгрөг зарцуулав. Аймгийн хэмжээнд 2022 онд хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих 29 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 6 хэргээр өссөн байна.</p>	70.0
4.3.4	Хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан өргөжүүлнэ.	<p>Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Хүрч үйлчилье” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, 16 сум, 1 тосгоны 446 хүүхэд, 280 иргэнээс тоон судалгаа, 297 хүүхэдтэй бүлгийн ярилцлага зохион байгуулж, чанарын судалгаа авсан. Судалгааны үр дүнг нэгтгэн сумдын Засаг дарга бөгөөд хамтарсан багийн ахлагч, хүүхдийн төлөө зөвлөлийн даргад зөвлөмж хүргүүлэн 1761 хүүхэд үе тэнгийн дээрэлхэлт, эерэг хандлага, 220 багшид “Багшийн өс зүй” сэдэвт сургалтыг тус зохион байгууллаа. Мөн сургалтыг 16 сум, 1 тосгоны 225 иргэнд хийж, эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 36 хүүхдийг бүртгэл судалгаанд авч, эцэг, эх, асран хамгаалагч нарт нь хүүхдийн эрхийг зөрчихгүй байх талаар зөвлөгөө өгөв. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн сэрэмжлүүлэг мэдээ, контент, нийтлэлийг “Сайхан Монгол” телевиз, FM радио, “Булганы мэдээ” сонин болон олон нийтийн цахим сүлжээгээр сурталчлан ажиллаж байна. Тус ажилд орон нутгийн төсвөөс 1.0 сая төгрөг зарцуулжээ.</p> <p>2022 онд Эрүүгийн хуулийн 13.1-т заасан хүн худалдаалах болон мөн хуулийн 16.1-т заасан хүүхдийн эсрэг гэмт хэрэг бүртгэгдээгүй, хүчиндэх гэмт хэрэг 18 бүртгэгдэж, 1 хэргээр буюу 5.3 хувиар буурсан.</p>	70.0

4.3.5	Стандартын шаардлагад нийцсэн цагдан хорих, баривчлах байрыг шинээр барьж ашиглалтад оруулна.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь баривчлах шийтгэл эдлүүлэх үйл ажиллагааг энэ оны эхнээс хэрэгжүүлж эхэлсэн ба тус ажлын хүрээнд цагдан хорих байрны 26 хүний багтаамжтай 1-5 дугаар өрөө болон коридорт иж бүрэн засвар үйлчилгээ хийж дуусгав. Эрүүлжүүлэх, саатуулах байрны зураг төсвийг аймгийн төсвийн хөрөнгөөр хийлгэсэн. Тус барилгын төсөвт өртөг 974.6 сая төгрөг бөгөөд 2023 оны улсын төсөвт тусгуулах саналыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд уламжиллаа.	100
4.3.6	Архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулна.	Архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах ажлын хүрээнд архивын зориулалтын байртай болох зорилгоор аймгийн Засаг даргын 2021 оны А/348 дугаар захирамжаар Архивын тасагт Булган сумын 5 дугаар баг Сансар-2 цэцэрлэгт хүрээлэнгийн зүүн талд 1373 м.кв газрыг албан конторын зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн. Төрийн Архивын тасагт төрийн байгууллагын газар эзэмших эрхийн бүртгэлийн Э-0405000803 дугаарт бүртгэл бүхий 000011712 дугаартай гэрчилгээг авсан. Архивын тасгийн барилгын зураг төслийн ажлыг ОСИБ ХХК 58.8 сая төгрөгөөр бүрэн хийж дуусгаад байна.	100
4.3.7	Хуулийн салбарын байгууллагуудын автомашин, тусгай зориулалтын техник хэрэгслийн хангалтыг үе шаттайгаар шинэчилж, ажиллах орчныг сайжруулан үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Орон нутгийн төсвийн 50.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн Цагдаагийн газарт БНСУ-д үйлдвэрлэсэн N.County маркын 22 хүний суудалтай бага оврын автобусыг нийлүүлсэн. Аймагт томилогдон ажиллаж байгаа Шүүхийн шиинжилгээний албаны кримниластикийн шинжээч болон шинжээч эмч нарыг тогтвор суурьшилтай ажиллаж, амьдрахад зориулж аймгийн төсвийн 60.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2 өрөө байр худалдан авах тендэрт "Гурван уулын хиши" ХХК шалгарч худалдан авах ажиллагааг зохион байгуулж, орон сууцыг албаны хэрэгцээнд ашиглаж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих 439 дүгээр ангид алба хаагчдын спорт заалны барилгын 1.8 тэрбум төгрөгийн төсвийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцад тусгалаа. Энэ онд 630.0 сая төгрөг батлагдаж, спорт заалны ажлын гүйцэтгэл 60.0 хувьтай байна.	100
4.3.8	Иргэдэд эрх зүйн албан бус боловсрол олгох чиглэлээр хөтөлбөр батлуулан хэрэгжүүлнэ.	"Бүх нийтийн эрх зүйн боловсрол" хөтөлбөрийн хүрээнд төрийн 68 байгууллагын 2782 алба хаагч, 4175 иргэн, ЕБС-ийн 3085 сурагчид танхимын хэлбэрээр холбогдох хууль, эрх зүйн мэдээллээр сургалт зохион байгуулсан. Мөн аймгийн 16 сум, 1 тосгоны Эрх зүйн хөтөч цахим хуудсаар дамжуулан 287 төрлийн хууль, эрх зүйн мэдээллийг байршуулан давхардсан тоогоор 4324 иргэн үзсэн байна. Эрх зүйн хөтөч нар нь шинээр мөрдөгдөж буй хуулиудаар бэлтгэсэн 1700 ширхэг гарын авлага, хууль хяналтын байгууллагуудын эрх зүйн 1600 ширхэг зөвлөмж, материалыг 2856 малчин иргэнд хүргэж ажилласан. Хамтран ажиллах гэрээний хүрээнд "Буйлхан ногоон төгөл" ТББ-тай хамтран шинээр мөрдөгдөж буй хуулиудаар 6 удаагийн подкаст бэлтгэн иргэдэд сурталчилсан. Мөн авлигын тухай хууль, ашиг сонирхлын зөрчлийн тухай ойлголт өгөх зорилгоор "Булганы өнгө" ТББ, "Хотуга" НҮТББ-тай хамтран хууль тогтоомжуудыг иргэд, төрийн албан хаагчдад сурталчлан ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн төсвөөс 15.0 сая төгрөг зарцуулсан ба 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьтай байна.	100
4.3.9	Аймаг, сумын гамшгийн эрсдэлийн үнэлгээ, тойм судалгаа хийж, гамшиг аюулт үзэгдлийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч, техник тоног төхөөрөмжөөр үе шаттай хангана.	Гал түймэр унтраах, аврах 20, 50 дугаар анги, Эрэн хайх, аврах салбар Булган сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль, Хангал сумын Хялганат тосгоны Захирагчийн ажлын албатай хамтран эрэн хайх болон гал түймэр унтраах тактикийн сургуулийг 03 дугаар сарын 23-нд зохион байгууллаа. Тус дадлага, сургуульд аймгийн 16 сум, 1 тосгоны хэмжээнд 230 байгууллага, аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн 7703 иргэн, 153 автомашин, техник хэрэгсэл хамрагдав. Мөн 4, 5 дугаар сард аймгийн Засаг даргын нэрэмжит Гамшгаас хамгаалах хяналт шалгалт, сургалт зохион байгуулах удирдамжийн дагуу Онцгой байдлын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар хамтран 2 ажлын хэсгийг 16 суманд ажиллуулж, сумын Засаг дарга, Онцгой комисс, байгууллага, аж ахуйн нэгжид Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Ойн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт хийж, удирдах бүрэлдэхүүн, мэргэжлийн анги, ажилтан, иргэд, сурагчдад Гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг 62 удаа 17009 хүнд зохион байгуулсан. 2022 оны 10 дугаар сард Могод, Орхон, Сайхан, Сэлэнгэ суманд Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газрын хамтарсан ажлын хэсэг гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль, дадлагыг зохион байгууллаа. Энэ онд Онцгой байдлын ерөнхий газраас аймгийн Онцгой байдлын газарт 2 автомашин шийдвэрлэн олгов.	100
4.3.10	Хутаг-Өндөр суманд эрэн хайх, аврах бүлгийг байгуулж, бэлэн байдлыг хангана.	Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхийг сайжруулах зорилгоор Хутаг-Өндөр суманд шинээр эрэн хайх, аврах салбар байгуулж, байр, шуурхай дуудлагын 2 автомашин, автомашины тавиуланг барьж, 2022 оны 10 дугаар сард Эрэн хайх, аврах салбарын нээлтийн арга хэмжээ болов.	100

4.3.11	Батлан хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлж, орон нутгийн хамгаалах тогтолцоог бэхжүүлнэ.	<p>Аймгийн 16 сум, 1 тосгоны "Зэвсэгт хүчний ангийг дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөө", "Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө"-нд 5, 10 дугаар сард тодотгол хийсэн. Дайчилгааны II зэргийн бэлтгэл үүрэгтэн 20 иргэнийг цэргийн анхан шатны бэлтгэл олгох сургалтад Зэвсэгт хүчний 110 дугаар ангид 10 хоногийн хугацаанд төвлөрүүлэн зохион байгууллаа. Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын маш нууц удирдамжийн дагуу аймгийн "Зэвсэгт хүчний ангийг дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөө"-г боловсруулан Зэвсэгт хүчний Жанжин штабын даргаар батлуулсан. Тус төлөвлөгөөний дайчилгааны даалгаврын дагуу 16 сум, 1 тосгоны дайчилгааны төлөвлөгөөг боловсруулж, аймгийн Засаг даргаар батлуулан сумын Засаг дарга нарт хүлээлгэн өгсөн. Дайчилгааны тухай хууль болон Батлан хамгаалахын сайдын аймгийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээний дагуу аймгийн Засаг даргын 2022 оны А/465 дугаар захирамжаар Төвийн бүсийн аймгуудын сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарт явуулах "Цэргийн бэлтгэл" сургалтыг 2022 оны 08 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабтай хамтран зохион байгуулав. Сургалтад Архангай, Булган, Хөвсгөл, Өвөрхангай, Орхон, Дархан, Сэлэнгэ аймгийн сумдын ЗДТГ-ын дарга, Цэргийн штабын дарга, офицер, Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын төлөөлөл, нийт 110 бие бүрэлдэхүүн хамрагдсан. Засгийн газрын 2021 оны 120 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 38 иргэнийг цэргийн дүйцүүлэх албанд элсүүлэн авч эхний жилд алба хааж байгаа иргэдэд цэргийн анхан шатны бэлтгэл дадлага олгох сургалтыг аймгийн Засаг даргын 2022 оны А/551 дүгээр захирамжаар 9 дүгээр сарын 10-24-нд 14 хоногийн хугацаатай Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн сургалтын төвд зохион байгууллаа. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 5 давхарт Цэргийн штабын сургалтын танхим байгуулж, 3.0 сая төгрөгөөр 20 ширээ, 40 сандал, сургалтын самбар, проектор зэргийг авч, сургалт үйл ажиллагаа явуулж байна. Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 101 жилийн ойг тохиолдуулан Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд "Марш тактик-тусгай бэлтгэл"-ийн тэмцээнийг зохион байгуулсан. Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд аймгийн аварга шалгаруулах цэрэг спортын "Дөл" цогцолбор тэмцээнийг зохион байгуулж, эхний 3 байрт шалгарсан сурагчид улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцсон. Үндэсний батлан хамгаалах их сургуульд 4 төрийн алба хаагчийг бэлтгэл офицерийн анхан шатны сургалтад хамруулав. Хил хамгаалалтад туслах хүчний 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймгийн хэмжээнд "Монгол цэрэг-Монгол морь" аяныг зохион байгуулсан. Аяны хүрээнд 16 сумын иргэдээс 68 агт Хилийн цэргийн 0286 дугаар ангид хандивласан.</p>	86.0
--------	---	--	------

ТАВ. БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

5.1. Бүс, орон нутгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.

5.1.1	Булган, Орхон суманд бетон зуурмагийн үйлдвэр байгуулж, үйл ажиллагааг тогтворжуулна	<p>Булган сумын 1-р баг Байгаль орчин-4 гудамж 410 тоот байршилтай газарт "Дэвших конкрет" ХХК-ийн бетон зуурмагийн үйлдвэр ашиглалтад орж, 540 гаруй тн зуурмаг орон нутгийн барилга бүтээн байгуулалтад нийлүүлсэн байна. Цементийн хомсдол, үнийн өсөлтөөс шалтгаалж бүрэн хүчин чадлаараа ажиллаагүй байна. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Мэргэжлийн хяналтын газар, Булган сумын Засаг даргын Тамгын газрын ажлын хэсэг үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай танилцаж, зөвлөмж өгч ажиллав.</p>	100
5.1.2	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлж, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.	<p>Улсын бүсчилсэн хөгжлийн төлөвлөгөөнд манай аймагт махны агро парк байгуулахаар тусгагдаж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны холбогдох мэргэжилтнүүд Булган суманд ажиллаж, мах боловсруулах үйлдвэрийн байршил, дэд бүтцийн асуудлыг судлан БНХАУ-ын 19.5 сая ам долларын хөнгөлөлттэй зээлийн дэмжлэгээр "Махны үйлдвэр, хорио цээрийн бүс бүхий цогцолбор" барихаар шийдвэрлэсэн. Булган сумын 4 дүгээр баг Домын дэвсгэт 91302 м.кв талбай бүхий газрыг хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолборын зориулалтаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд 15 жилийн хугацаатай газар эзэмшүүлээд байна.</p> <p>Сумдад мал нядалгааны зөөврийн цэг байгуулах зураг төсвийг "Оргил цамхаг констракшн" ХХК-аар хийлгүүлээ. Хангал суманд "Хялганат эко мах" ХХК нь хоногт 50 бод, 200 бог мал нядалах хүчин чадалтай, 50 тоннын багтаамжтай хөргүүртэй агуулах бүхий үйлдвэр ашиглалтад оруулсан. "Бүрэн луу" ХХК-д концессоор эзэмшүүлсэн "Мал, мах бэлтгэлийн цех" ашиглалтад оров. Бүрэгхангай, Хутаг-Өндөр сум мал нядалгааны цэгийн газрын асуудлыг шийдвэрлээд байна. Булган, Орхон аймгийн Засаг дарга нарын хамтран ажиллах гэрээнд тусгагдсаны дагуу хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн чөлөөт худалдаа хийгдэж байна. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг өргөтгөх, сурталчлах зорилгоор "Өвлийн идэш", "Цагаан сар", "Алтан намар", Намрын ногоон өдрүүд үзэсгэлэн худалдаанд үйлдвэрлэгч, малчид, иргэдийг зохион байгуулан оролцууллаа.</p>	76.7

5.1.3	Өрхийн орлогод нийцсэн, амины, түрээсийн гэх мэт инженерийн шийдэл бүхий орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, Булган суманд 150, сумдад 50-аас доошгүй айлын орон сууц барина.	Булган сумын 5 дугаар баг 186 байрны урд "Биг эко" ХХК-ийн захиалгаар 2 блок 84 айлын орон сууцны барилгын эхний 1-р блокны суурийн ажил 2021 онд хийгдсэн. Булган сумын 5-р багт "Булган өргөө" хотхоны 2 дугаар блок 28 айлын орон сууцыг "Их азар" ХХК барьж 2022 оны 4 дүгээр сард ашиглалтад оруулсан. Мөн Булган сумын 2 дугаар баг "Нарлаг өргөө" хотхоны баруун талд 25 айлын орон сууцыг "Их-Ураг" ХХК эхлүүлж, ажлын гүйцэтгэл 60.0 хувьтай явагдаж байна. Орхон, Сэлэнгэ, Хутаг-Өндөр суманд нийтийн орон сууц барихаар төлөвлөгдсөн газруудад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар инженерийн шугам сүлжээ татахаар 1.5 тэрбум төгрөг тусгагдаж, гүйцэтгэгчээр "Эрч арвин" ХХК шалгарч, ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Засгийн газрын хэмнэлтийн тухай бодлогын хүрээнд төсөвт тодотгол хийгдэн хөрөнгө оруулалтыг багасгаж баталсан тул энэ онд төлөвлөгдсөн 140.0 сая төгрөгийн ажлыг гүйцэтгэж дуусгаад байна.	70.0
5.1.4	Булган сум, хөдөөгийн сумын төв суурин газруудын үерийн далан суваг, ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	Булган сумын үерийн байгууламжийн нэгдсэн зураг төслийг 2016 онд "Гидро сооружение" ХХК боловсруулж, байгууламжийн 80.0 хувийг 2016-2021 онд гүйцэтгэсэн. Хужир толгойн үерийн сувгийн ажлын төсвийг шинэчилсэн. Хутаг-Өндөр сумын төвийн үерийн хамгаалалтын далан сувгийн угсралтын ажлын гүйцэтгэгчээр "Хангилцаг" ХХК шалгаран, 4.2 тэрбум төгрөгөөр гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 70.0 хувьтай энэ оны төлөвлөгөөт ажлыг гүйцэтгэсэн. Сайхан сумын төвийн үерийн хамгаалалтын далангийн ажлын гүйцэтгэгчээр "Хайдро проект" ХХК шалгаран 2020 онд 426.7 сая төгрөгөөр гэрээ байгуулсан. Далангийн ажлын гүйцэтгэл 70.0 хувьтай үргэлжилж байх явцад үер буусны улмаас ажлын тоо хэмжээнд өөрчлөлт орж, 2022 онд Барилга, хот байгуулалтын сайдын багцаас 200.0 сая төгрөг нэмэлтээр шийдвэрлүүлсэн ба далангийн ажлыг энэ онд бүрэн дуусгаж ашиглалтад хүлээн авахаар ажиллаж байна.	85.0
5.1.5	Инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ажлыг үргэлжлүүлнэ.	Булган сумын 4 дүгээр ус, дулаан дамжуулах төвөөс "Дэлгэрэх өргөө" нийтийн орон сууц, Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийг дулаан, цэвэр, хэрэгцээний халуун усны шугамд холбох ажлыг "Марвель хаус констракшн" ХХК гүйцэтгэж, холбогдох туршилт, тохируулгыг хийж дуусган ашиглалтад оруулсан. Сэлэнгэ сумын төвийн төвлөрсөн дулаан хангамжийн системийн угсралтын ажлыг төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр "Долоон бар" ХХК 2021-2022 онд гүйцэтгэж, 2022 оны 04 дүгээр сард ашиглалтад оруулан үйл ажиллагаа хэвийн явж байна. Баян-Агт суманд орон нутгийн төсвийн 400.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 970 м, Ф200 мм-ийн ариутгах татуургын шугам сүлжээ, 35 м.куб/хоног хүчин чадалтай сефтик цэвэрлэх байгууламжийн ажил хийгдэхээр зураг төслийн ажлыг "Их мянган инженерчлэл" ХХК боловсруулсан. Гүйцэтгэгчээр "Эрин гүрэн" ХХК шалгаран 2021 оны 09 дүгээр сарын 01-нд гэрээ байгуулан ажлыг эхлүүлж, 2022 оны 06 дугаар сарын 10-нд байнгын ашиглалтад оруулсан. Сайхан сумын цэвэр усны шугамын 700 м, Ф100 мм-ийн шугам, 1 ширхэг ундны ус түгээх ухаалаг худаг угсрах ажлыг орон нутгийн төсвийн 300.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Тэнгэр хишиг" ХХК гүйцэтгэж, ашиглалтад хүлээлгэн өгсөн.	100
5.1.6	Авто зам, замын байгууламжийг өргөтгөж, Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сум чиглэлийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл 99.7 км, Хялганат-Хангал-Эрдэнэт чиглэлийн 53.6 км хатуу хучилттай авто замыг барьж, ашиглалтад оруулна.	Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сум чиглэлийн 99.7 км хатуу хучилттай авто замын ажлын үргэлжлэлийн хөрөнгө оруулалт болох 31.08 км авто замын төсвийг 2022 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтад 1270.8 сая төгрөг тусгаж, ажлын гүйцэтгэгчээр "РЭС" ХХК шалгарч Зам тээврийн хөгжлийн төвтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулан энэ оны авто замын төлөвлөгөөт ажлыг гүйцэтгээд байна. Эрдэнэт хотоос Хангал сумын төв хүртэлх орон нутгийн чанартай 30 км авто замын ажлын гүйцэтгэгчээр "Замын битум" ХХК, Хангал сумын төвөөс Хялганат тосгоны төмөр бетон гүүр хүртэлх 23.6 км авто замын ажил гүйцэтгэгчээр "Хурдны зам" ХХК, Хангал сумаас Хялганат тосгон хүртэлх авто замын дундаас Эрдэнэт үйлдвэрийн "Сэлэнгэ" амралтын бааз, Олимпын тамирчдын бэлтгэлийн бааз буюу 1-р подем чиглэлийн 10.4 км авто замын ажлын гүйцэтгэгчээр "Жавхланта харгуй" ХХК тус тус шалгарч энэ онд хийгдэх төлөвлөгөөт ажлыг хийж гүйцэтгээд байна.	70.0
5.1.7	Багийн төвүүдийг үүрэн телефон сүлжээнд хамруулж, нутаг дэвсгэрийн хэмжээгээр үүрэн холбоо, өндөр хурдны интернет ашилах нөхцөлийг бүрдүүлнэ.	2022 онд Юнител компани Бугат, Бүрэгхангай, Дашинчилэн, Могод, Орхон, Рашаант, Сайхан, Тэшиг, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сумын 14 багийг шинээр сүлжээнд холбосон. Мөн Булган сумын 6д хороолол болон 3 дугаар баг, "Жаргалант" зуслан гэсэн 3 газарт шинээр цамхаг босгож, сүлжээний өргөтгөл хийв. Мобиком компани Орхон сумын Халиун багт, Сайхан сумын Угалз, Ундрах гэх 3 багт шинээр сүлжээний цамхаг босгон ашиглалтад оруулснаар энэ онд нийт 20 байршил үүрэн холбооны сүлжээнд холбогдов.	100
5.1.8	Цахилгаан, эрчим хүчний хангамжийг сайжруулж, найдвартай ажиллагааг дээшлүүлнэ.	Дэлхийн банкны төслөөр хэрэгжиж буй ухаалаг тоолуурын системийг нэвтрүүлэх ажлын хүрээнд хийгдэх төмөр бетон тулгуур, 0.4 кВт-ын 7 км кабель, 10 кВт-ын 2 км кабель болон 400 кВт, 250 кВт, 160 кВт-ын 8 дэд станцын ажлыг гүйцэтгэж, 3715 айл өрхөд 2 тарифт тоолуур суурилуулан хэрэглэгчдийг найдвартай цахилгаан эрчим хүчээр хангаж байна.	100

5.1.9	Цөлжилтийн төлөв байдлын судалгаа хийж, тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	<p>Дашинчилэн, Рашаант суманд элсний нүүдлийг тогтоон барих зорилгоор 5 га талбайд ойн зурвас байгуулах ажлын тендерт Дашинчилэн суманд "Хөвөнтөн ой" ХХК шалгарч аймгийн Засаг даргын 2022 оны А/336 дугаар захирамжаар гэрээ байгуулж 2.5 га талбайд 3000 ширхэг мод тарьснаас 2236 ширхэг мод ургаж, нөхөн тарилт хийлгэж амьдралтын 90.7 хувьтай аймгийн комисс хүлээн авсан. Рашаант сумын Элсэн тасархайд "Газарзүй, геоэкологийн хүрээлэн" шалгарч аймгийн Засаг даргын 2022 оны А/606 дугаар захирамжаар гэрээ байгуулан хашаа хамгаалалт, тарилтын ажлыг 100 хувь хийж гүйцэтгэлээ.</p> <p>Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний 64.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баяннуур, Гурванбулаг, Дашинчилэн, Рашаант, Сайхан сумын 40.0 мянган га бэлчээрийн талбайд хөнөөлт мэрэгч амьтадтай тэмцэх ажлыг энгийн механик, микробиологийн аргаар зохион байгуулсан.</p>	100
-------	--	--	-----